

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



2025 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 10-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-7
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	8-44
<hr/>	
1.Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	9-16
2.Монгол Улсын Засгийн газар болон Монгол, Францын хамтарсан “Бадрах Энержи” ХХК-ийн хөрөнгө оруулагч Орано Майнинг С.А.С компани хооронд байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төсөл /Засгийн газар 2025.01.08-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/	16-42
3.Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг танилцуулах	42-44

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр /Баасан гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 85 гишүүн хүрэлцэн ирж, 67.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 29 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Баясгалан, Ш.Бямбасүрэн, Х.Жангабыл,
Л.Мөнхбаясгалан, Т.Мөнхсайхан, Ж.Энхбаяр;

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Д.Батбаяр, Х.Баттулга, П.Батчимэг,
Э.Батшугар, Ж.Ганбаатар, Ц.Мөнхбат, Б.Мөнхсоёл, П.Мөнхтулга,
З.Мэндсайхан, Б.Найдалаа, М.Нарантуяа-Нара, Л.Оюун-Эрдэнэ, Б.Тулга,
О.Цогтгэрэл;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, Х.Болормаа, С.Лүндэг, М.Мандхай,
Б.Түвшин, Д.Цогтбаатар, Ө.Шижир, Б.Энхбаяр;

Хоцорсон: О.Алтангэрэл-07 минут, С.Амарсайхан-08 минут,
М.Бадамсүрэн-07 минут, Р.Батболд-12 минут, Ж.Галбадрах-08 минут, Х.Ганхуяг-
01 минут, Б.Жавхлан-44 минут, Б.Заяабал-15 минут, С.Одонтуяа-25 минут,
Д.Пүрэвдаваа-08 минут, Н.Учрал-45 минут.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу “Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог, хэрэв төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол Зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлнэ.” гэж заасны дагуу Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төслүүдийг Засгийн газраас 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр өргөн мэдүүлснийг Эдийн засгийн байнгын хороонд, “Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газраас 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр өргөн мэдүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хороонд, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Малчны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газраас 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр өргөн мэдүүлснийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд тус тус хуваарилсныг мэдээлэв./16:32/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 95.3-т заасны дагуу иргэн Насантогтохын Анхзаяагаас Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрөөс “Нарансэвстэйн боомтыг сэргээж, нээх” гэсэн хэсгийг хасуулах асуудлаар ажлын хэсэг байгуулах тухай асуудлаар нийтийн өргөдлийг хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр ирүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулав./16:34/

Нэг.Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Цолмон, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Т.Ганбаатар, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, мөн компанийн Хууль, эрх зүйн зөвлөлийн дарга Б.Гэрлээ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, Байнгын хороодын ажлын албаны референт А.Хонгорзул нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрахын тавьсан асуултад “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал, С.Ганбаатар нар үг хэлэв.

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т заасны дагуу хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулав.

Д.Амарбаясгалан: 1.Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Татгалзсан: 22
Бүгд: 96
77.1 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, Б.Хэрлэн, Ж.Чинбүрэн нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 96 гишүүнээс 77 гишүүн дэмжиж, 80.2 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 79
Татгалзсан: 18
Бүгд: 97
81.4 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Хоёр.Монгол Улсын Засгийн газар болон Монгол, Францын хамтарсан “Бадрах Энержи” ХХК-ийн хөрөнгө оруулагч Орано Майнинг С.А.С компани хооронд байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төсөл /Засгийн газар 2025.01.08-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Цолмон, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Н.Жамъянхүү, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлого зохицуулалтын газрын дарга Ц.Уранчимэг, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, мөн яамны Геологи, уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч Ц.Өнөрнасан, Хуулийн хэлтсийн дарга Т.Ганбаатар, Ашигт малтмал, газрын тосны газрын Геологи ашиглалтын газрын дарга С.Ган-Очир, Усны газрын дарга З.Батбаяр, Татварын ерөнхий газрын Том татвар төлөгчийн газрын дарга С.Төгсжаргал, Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга Б.Болдбаатар, Цөмийн энергийн комиссын ажлын албаны дарга Г.Манлайжав, мөн албаны Цөмийн технологийн бодлогын газрын дарга М.Чадраабал, Шинжлэх ухааны академийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн захирал Л.Жаргалсайхан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх А.Мандуул, Б.Хулан, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, мөн компанийн Хууль, эрх зүйн зөвлөлийн дарга Б.Гэрлээ, Геологи, үйлдвэрлэлийн бодлогын газрын дарга Ц.Төгсбуян, Хамтын ажиллагааны хэлтсийн менежер Т.Төрбадрах, “Мон Атом” ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Далайжаргал, мөн компанийн Захиргааны удирдлагын албаны дарга Д.Сугарсүрэн, Уул уурхайн ахлах инженер А.Алтанхундага, “Эрдэнэс Оюутолгой” ХХК-ийн Геологи, уул уурхайн хэлтсийн ерөнхий менежер Л.Өнөрбаяр, мөн

компанийн Санхүү шинжилгээний хэлтсийн ерөнхий менежер Б.Бат-Өлзий, Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ц.Мөнх-Оюунбаатар, Олон улсын харилцааны судлаач, профессор Д.Баярхүү, Физикийн ухааны доктор Н.Тэгшбаяр, Монголын мал эмнэлгүүдийн дундын хоршооны зөвлөх, академич Я.Ганболд, Дотоод хуулийн зөвлөх Г.Мөнхболд, Б.Батмандах, С.Батхүлэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

Төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, С.Эрдэнэбат, П.Сайнзориг, Д.Үүрийнтуяа, О.Саранчулуун, Ж.Золжаргал, С.Ганбаатар, Д.Ганбат нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү, “Мон Атом” ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Далайжаргал, Олон улсын харилцааны судлаач, профессор Д.Баярхүү, Физикийн ухааны доктор Н.Тэгшбаяр, Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга Б.Болдбаатар, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлого зохицуулалтын газрын дарга Ц.Уранчимэг, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, О.Саранчулуун, Ж.Золжаргал нар үг хэлэв.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар Монгол Улсын Засгийн газар болон Монгол, Францын хамтарсан “Бадрах Энержи” ХХК-ийн хөрөнгө оруулагч Орано Майнинг С.А.С компани хооронд байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг бүхэлд нь зөвшөөрч, тухайн гэрээнд гарын үсэг зурах эрхийг Монгол Улсын Засгийн газарт олгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	71
Татгалзсан:	26
Бүгд:	97

73.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Х.Ганхуяг, С.Замира, М.Ганхүлэг, Т.Доржханд, С.Цэнгүүн нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 97 гишүүнээс 77 гишүүн дэмжиж, 79.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг зөвшилцсөн тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцож, Улсын Их Хурлын *тогтоолыг танилцуулав./18:44/*

Уг асуудлыг 18 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг танилцуулах

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан дараах хуулиудын эцсийн найруулгыг танилцуулав. Үүнд:

1.Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:48/

2.Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:51/

3.Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:52/

4.“Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг зөвшилцсөн тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн үг хэлэв. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./18:52/

Уг асуудлыг 18 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 2 цаг 24 минут үргэлжилж, 126 гишүүнээс 97 гишүүн хүрэлцэн ирж, 76.1 хувийн ирцтэйгээр 18 цаг 53 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

*2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр, Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
16 цаг 29 минут*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хороодын хуралдаан дуусаад Улсын Их Хурлын нэгдсэн чуулган эхлэхэд бэлэн болсон байна. Чуулганы нэгдсэн хуралдааны ирц 60.3 хувьтай байна. Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаан эхэлснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанаар дараах 3 асуудлыг хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Хоёрдугаарт, Монгол Улсын Засгийн газар болон Монгол, Францын хамтарсан “Бадрах Энержи” ХХК-ийн хөрөнгө оруулагч “Орано Майнинг С.А.С компани хооронд байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний төслийг зөвшилцөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

Гуравдугаарт, Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсоно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог, хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж заасан.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя.

1.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төслүүдийг Засгийн газраас 2025 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр өргөн мэдүүлснийг Эдийн засгийн байнгын хороонд,

2.“Нийслэл Улаанбаатар хотыг 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газраас 2025 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр өргөн мэдүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хороонд,

3. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Малчны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газраас 2025 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр өргөн мэдүүлснийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд тус тус хуваарилсан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 95.1-д нийтийн өргөдлийг дэмжсэн иргэдийн санал энэ хуулийн 95.2-т заасан тоонд хүрмэгц Улсын Их Хурлын дарга саналыг хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр холбогдох Байнгын хороонд ажлын 5 өдрийн дотор хуваарилж, нэгдсэн хуралдаанд танилцуулна гэж заасан.

Нийтийн өргөдлийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя.

Иргэн Насантогтохын Анхзаяа нийтийн ашиг сонирхлыг хөндсөн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрөөс “Нарансэвстэйн боомтыг сэргээж, нээх” гэсэн хэсгийг хасуулах асуудлаар ажлын хэсэг байгуулах тухай нийтийн өргөдөл ирүүлснийг Улсын Их Хурлын нийтийн өргөдөл, гомдлын системд 2024 оны 12 дугаар сарын 4-ний өдөр нийтэлсэн.

Энэ өргөдөл 2025 оны 1 дүгээр сарын 6-ны өдөр Монгол Улсын 18 насанд хүрсэн 33037 иргэний санал авсан тул нийтийн өргөдөлд дурдсан асуудлыг хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний дагуу Төрийн байгуулалтын байнгын хороонд хуваарилж байна.

Төрийн байгуулалтын байнгын хороо иргэдийн гаргасан өргөдөлд дурдсан асуудлыг хуульд заасны дагуу хэлэлцэн шийдвэрлэх, шаардлагатай бол холбогдох Байнгын хороодтой хамтран хэлэлцэх нь зүйтэй.

Хэлэлцэх асуудалд оръё.

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дэд дарга Бөхчулууны Пүрэвдорж танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулган 2025 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн нэгдсэн хуралдаанаараа явуулж, төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан явуулж, чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дарааллыг жигдлэх хууль зүйн техникийн засваруудыг хийж, хуулийн төслүүдийн эцсийн хувилбарыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн хууль тогтоомжоор стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудыг тодорхойлж батлахдаа ашигт малтмалын нэр төрлөөс, эсхүл тусгай зөвшөөрлөөр нь хамааруулан ангилах талаар Засгийн газраас баримтлах бодлого, төрөөс газрын тосны салбарт баримтлах бодлогын талаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл цаашид цацраг идэвхт ашигт малтмалын геологийн хайгуул, судалгааны ажилд зориулж хэдий хэмжээний санхүүжилт хийхээр төлөвлөж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж Үндэсний баялгийн санд хуримтлагдсан хөрөнгийг тогтвортой хадгалах, арвижуулах асуудлаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж, хуулийн төслийг баталж өгөхийг хичээнгүйлэн хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Пүрэвдорж гишүүнд талархал дэвшүүлье. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Ням-Осорын Учрал Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Дорждэрэмийн Цолмон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Дэд дарга, Доржсүрэнхорлоогийн Саруул Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Гүнчинсүрэнгийн Намчинсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга, Туулхангайн Ганбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хуулийн хэлтсийн дарга, Санжаагийн Наранцогт “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал, Балжиннямын Гэрлээ “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Хууль, эрх зүйн зөвлөлийн дарга.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

Жанчивын Галбадрах гишүүн асуулт асууна.

Ж.Галбадрах: Та бүхний энэ өдрийн амгаланг эрье.

Бидний хувьд хөгжлийн алтан үе ирж байна уу гэж бодож байна. Яагаад гэвэл Үндэсний баялгийн сан маань бүрэлдээд, хууль нь батлагдаад 8 сарын дотор гэхэд бид нар тодорхой хэмжээний хуримтлал үүсгээд, энийгээ зарцуулаад ингээд явж байна. Тэгээд энд цаашдаа Хөгжлийн сан, Ирээдүй сан, Хуримтлалын сангууд маань үр дүнтэй байх, өөрөөр хэлбэл орлогоо бүрдүүлэх талаар бид бүхэн нэлээн хяналттай байя. Ялангуяа төрийн өмчийн компаниуд дээрээ маш сайн хариуцлага тооцож ингэж явах талаар нэлээн их хүмүүс ярилаа.

Тэгэхээр миний хувьд төвлөрсөн орлогыг яаж менежмент хийх вэ, яаж зарцуулах вэ гэдэг тал дээр хэдэн үг хэлье гэж ингэж бодож байна. Тэгээд бид нар хөгжлийн маань үндсэн концепц маань яг ямар байх вэ, бид нар хөгжлийг юу гэж харах вэ, ямар өнцгөөр харах вэ гэдэг зүйл дээрээ л бид нар сайн тогтох ёстой. Аливаа улс орон хөгжье гэвэл боловсролдоо л хөрөнгө оруулах ёстой гэдэг энэ зарчим. Ерөөсөө боловсрол л чанартай байж байж улс орон хөгжинө гэдэг энэ концепц олон зууны туршид батлагдаад ингээд ирсэн, олон улсын туршлагаар батлагдсан зүйл.

Тэгэхээр би бол энэ зарцуулалт дээр өчигдөр Учрал сайдын яриан дээр харж байхад бид нар Хөгжлийн сангаас өөрөөр хэлбэл төсвийн ашгаас, төсвийн ашигтай гарсан зардлаас зарцуулахад энэ боловсрол, эрүүл мэнд, орон сууцад зарцуулна гээд ярьсан. Тэгтэл энэ жил манай Хөгжлийн санд маань энэ 24 оны байдлаар, ирэх оны төсөөллөөр үзэхэд энэ тэнцвэртэй, алдагдалгүй төсөв ингээд батлаад явлаа гэхэд бид нарын энэ дотроос гарч ирэх, үнэхээр боловсролд зарцуулах тэр сангийн мөнгө гарч ирэх үү? Өчигдөр тэгээд Сангийн яамны төлөөллийн бас хэлж байгаагаар Хуримтлалын сангаас бид нар энэ боловсролдоо ингээд зориулах төсвүүд, хөрөнгө оруулалтыг гаргана гэсэн ийм зүйл яригдаж байна.

Тэгэхээр бид нар яг энийгээ бас их тодорхой болгоод, тодорхой хувь заагаад үнэхээр боловсролд маш их асуудлууд хуримтлагдсан байна. Хүүхдийн эрх ашиг зөрчигдөөд, даац нь хэтрээд чанартай сургалт явуулах ийм боломжгүй нөхцөлд сурч байгаа хүүхдүүдийн тоо 30 хувьд нь суралцагчид байна. Энэ Нийслэл болон ганцхан Нийслэлд байгаад байгаа шүү дээ. Нийслэл 72, орон нутагт 28 хувь нь. Ялт ч үгүй өнөөдөр бид нар энийг тэвчиж өнгөрч болохгүй ийм нөхцөлд боловсрол эзэмшиж байна. Энд чанар яригдахгүй байна гэдэг асуудал дээр бид нар боловсрол руу энийг нэлээн оруулах.

Нөгөө талаас боловсролын чанарыг бэлдэхийн тулд бид нар багш нарыг, шилдэг төгсөгчийг багш болдог энэ тогтолцоог бий болгох хэрэгтэй байна. Энд эдийн засгийн хөшүүргүүд хэрэгтэй. Тэгээд энэ эдийн засгийн хөшүүргийг бий болгохын тулд ялт ч үгүй л энэ Баялгийн сангийн бас гарч ирэх энэ зарцуулалт дээр бид нар амьжиргааны тэтгэлэг өгдөг, ипотекийн зээлд хамруулдаг, гадаадад бас магистрт сургадаг, мэргэжил дээшлүүлдэг гээд энэ багш хөтөлбөрийг, багшийг чанаржуулах тал дээр нэлээн ийм хөрөнгө оруулалт шаардлагатай байгаа ийм судалгаанууд, тооцооллууд гараад байгаа. Тэгээд энэ чиглэл рүү бид нар чиглүүлэх ёстой гэсэн ийм зүйл байна. Тэгэхээр ер нь энэ боловсролын чиглэл дээр яг тодорхой хувь заасан уу? Одоо бид нар ингээд ДНБ-ий тэдэн хувийг бид

нар боловсролд зарцуулъя, энэнээс байхгүй. Нийт зардлын ядаж 18 хувь, 10.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Нэмэлт 1 минут өгье.

Ж.Галбадрах: Тэгэхээр яг энэ боловсрол, эрүүл мэнд, орон сууц гээд ингээд бид нар ярьж байгаа бол энэ дотроо боловсрол, тэр дотроо дэд бүтэц, багшийн багшлах боловсон хүчнийг чанаржуулах тал дээр судалгаанууд хийгдсэн байгаа. Энэ судалгаанууд дээр бид нар хандаад, Сангийн яамнаас эхлээд ингээд хандаад явахад энэ тооцооллыг, энийг захиран зарцуулах, ямар хүмүүстэйгээ, ямар зарцуулах эрх тал дээр хамтарч ажиллах бид нар энэ тооцооллоо хэнд танилцуулж байх вэ гэдэг тал дээр бас тодорхой зүйлийг энийг асууж байна. Баярлалаа.

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал Наранцогт. Ажлын хэсгийн 18 дугаар микрофон.

С.Наранцогт: Галбадрах гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр Үндэсний баялгийн сангийн зарцуулалтын хувьд хуримтлалын сан өөрөө бэлэн бусаар орон сууц, боловсрол, эрүүл мэнд гээд энэний журмыг нь Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам ингээд батлаад явахаар байгаа.

Хөгжлийн сангийн хувьд энэ Эдийн засгийн яаман дээр Хөгжлийн санд хөрөнгө төвлөрсөн тохиолдолд улсын төсөвтэй цуг энэ улсын хөгжлийн дунд, урт хугацааны бодлогод тусгагдсан тэр төсөл, хөтөлбөрүүд, бодлоготой уялдуулж ингээд Их Хурлаар батлуулах ийм эрх зүйн орчинтой байгаа.

Тийм учраас таны саяын хэлж байгаа дэд бүтэц, сургууль соёлын асуудал энэ дээр холбоотой захиран зарцуулалт хийх бол энэ Эдийн засгийн яамнаас энэ асуудал боловсруулагдаад улсын төсөв батлагдах үед Үндэсний баялгийн сангийн хуулийн төсөл, төсөв хамтдаа ингээд орж ирээд ингэж батлагдах үед яригдана гэсэн үг.

Иргэдийн Хуримтлалын сангийн хувьд иргэд зөвхөн өөрийнхөө хэрэгцээний өөрийн болоод гэр бүлийн хэрэгцээний эрүүл мэнд, боловсрол, орон сууцад зарцуулах ийм зохицуулалттай байгаа.

Д.Амарбаясгалан: Отгоншарын Батнайрамдал гишүүн асуулт асууж, үг хэлье.

О.Батнайрамдал: Баярлалаа. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт ингээд эцэслэгдэх гэж байна л даа. Тэгэхээр энэ сошиалаар явж байгаа зүйлс ч гэсэн маргааш бас жагсаал болох юм гэсэн. Энэ бүхэн дандаа л газрын баялгийн хоорондын тэмцэл шүү дээ. Янз бүрийн шалтгаан гарч, бас янз бүрийн жагсаал болдог. Янз бүрийн санхүүжилттэй. Явж явж дандаа л газрын баялгийн өгөөжийг бид нар зөв, шударга хуваарилж чадах юм уу эсвэл яг хэдэн хүний гарт ингээд үлдээд л байх юм. Энэ зөвхөн Монгол Улсад тохиолдож байгаа зүйл биш. Ер нь байгалийн баялаг арвинтай зөндөө л орон байгаа юм.

Гэхдээ тэр орон дотроосоо энэ зөв хуваарилалтын механизмыг зөв ажиллуулж чадаад Баялгийн сангаар дамжуулж яг олон нийтэд тэр газрын баялгийн өгөөж нь Үндсэн хуулиараа дамжиж хүргэж чадсан уу гэдэгтэй л орнууд ер нь хоёр туйлд хуваагдаж болохоор байгаа юм.

Зөв хуваарилж очсон орнууд байна. Жишээлбэл, Норвег байна. Баялгийн сангаар дамжуулаад 1 хүнд ноогдох Баялгийн сангийн хөрөнгөөр авах юм бол энэ чинь 1 хүнд бараг 1 сая долларын хэмжээний орлогыг төвлөрүүлж чадсан байгаа шүү дээ. Эсвэл хэдэн бүлэглэлд очоод тэр нь буцаад тухайн орондоо газрын баялгийн буруу хуваарилалтаасаа болоод дотоодын дайн, зөрчил гарсан. Тэрийг баялгийн хараал гэж яриад байгаа юм л даа. Бас орнууд бас жишээ зөндөө байгаа юм.

Тэгэхээр энэ Үндсэн хуулийн зарчмын хүрээнд Үндэсний баялгийн сангаар дамжуулж бид нар энэ шударга хуваарилалтыг хийж чадах уу? Тэгэхээр яг энэ асуулт дээр бид нар цаашдаа ингээд зөв шийдлээ гаргаад явах юм бол бас газрын доорх баялгаасаа цаашаа эдийн засгаа солонгожуулаад өнөөдрийн бид мэдэж байгаа, тулгамдаж байгаа асуудлаа шийдээд явах магадгүй 10 жилийн дараа бид нар шал өөр, 5 жилийн дараа бид нар шал өөр асуудал дээр хүрсэн байх болно. Яг 2023 оны гүйцэтгэлээр аваад үзэх юм бол бид нарын 1 хүнд ноогдох ДНБ 6000 доллар хүрсэн.

Ер нь 10 жил 4000 дээрээ гацсан 1 хүнд ноогдох ДНБ бид нар 6000 болгоод энэ жилийн гүйцэтгэл яг гараагүй л байна л даа. Статистикийн төв хорооноос гаргах байх. Гэхдээ эдийн засгийн өсөлтийг тооцоод аваад үзэх юм бол ойролцоогоор 1 хүнд ноогдох ДНБ 6800, 6900 дээр хүрэх болов уу. Энэ бас л дахиад л бид нар 1 хүнд ноогдох дотоодын бүтээгдэхүүнээ түүхэн хэмжээнд гаргаж ирж байгаа юм. Энэнээс цааш дахиад 10000 хүрэхэд бол яг л дахиад л байгалийн баялагтай холбоотой томоохон төслүүд, түүнийг дагасан дэд бүтцийн мега төслүүд бид нар хэрэгжүүлэх л ёстой болж таарна. Энэ дахиад л яг зөвхөн Монгол Улсын хийж байгаа зүйл биш л юм л даа. Яг 1 хүнд ноогдох дотоодын бүтээгдэхүүнээрээ 5, 6 мянгаас үсрэнгүй 10, 12, 15 хүрсэн орнууд яг л томоохон дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлсэн байдаг. Энэ биднийг дараагийн шатад яг гаргах тэр шилжилтийн үе дээрээ л бид бүхэн яг явж байна. Энэ өнөөдрийн баталж байгаа Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт ч гэсэн яг тэр гогцоонуудын бас нэг мөнөөс мөн.

Тэгэхээр яг энэ үед бид нар Үндэсний баялгийн сангийн тухай хууль, мөн Ораногийн гэрээ давхар явж байна, төмөр замын томоохон бүтээн байгуулалт дандаа л байгалийн баялагтай холбоотой байгаа биз? Байгалийн баялагтай холбоотой мега төслүүд урагшлуулах зохицуулалт. Тэгэхээр энийг л бид нар яаж ийгээд, ямар нэгэн эсэргүүцэл тэр жагсаалын ард нь гарч энийгээ л бид нар зөв хуульчилж, зөв зарчим руу л бид нар заавал оруулах ёстой. Тэгж.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Нэмэлт 1 минут өгье.

О.Батнайрамдал: Баярлалаа. Тэгж чадах юм бол бид нар ер нь Монгол Улсын эдийн засаг чинь том дүнгээр нь аваад үзэх юм бол 20 орчим тэрбум их тийм том эдийн засаг биш байхгүй юу. Бид нар 10000, 12000 хүргэхэд бол хэдхэн том төсөл урагшаа зөв яваад, Үндэсний баялгийн сангаар дамжуулаад олон

нийтэд зөв хуваарилалт нь явахад бид нар сэвх л явчих энгийн эдийн засаг байхгүй юу.

Тэгэхээр энийг ямар ч эсэргүүцэл тулгарсан байя, ямар ч сошиалаар зөндөө харлуулах, борлуулах ажил явсан бай бид нар заавал ард нь гарч чадах чадах ёстой. Хэрвээ тэгж чадах юм бол бид нар энэ 126 гишүүнтэй шинэ парламентын өв болж үлдэх болов уу л гэж бодож байгаа юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууна. 2 гишүүний дараа санал хураалт байгаа. Гишүүдийг чуулганы танхимд хүрэлцэн ирэхийг урьж байна. Хууль эцэслэн батална.

С.Ганбаатар: Монгол орон маань цөөн хүн амтай хэдий ч гэсэндээ маш их баялагтай. Цөөхөн хүн амтай их баялагтай орны хувьд хамгийн гол анхаарах ёстой зүйл гэвэл нийгэмдээ яаж үйлчлэх вэ, нийгэмдээ яаж үр шимтэй байх вэ л гэдэг явдал.

Тэр утгаараа бид 6.1, 6.2 Үндсэн хуульд заасан “баялаг бол гагцхүү ард түмний мэдэлд гэж” заасан. Энэ цаад утгаараа гагцхүү ард түмнээс мандат авсан энэ 126 хүн ард иргэдийн баялгийн тухай шийдвэр гаргана л гэсэн үг. Тэгэхлээр энэ 126 хүн бүгдээрээ эрдэмтэй, мэдлэгтэй, уурхайн талаар баялгийн талаар мэдээлэлтэй, мэдлэгтэй гэсэн үг биш. Бидэнд мандат авсан. Харин энэ асуудал, энэ хуульд гол ярих зүйл бол бие даасан хөндлөнгийн шинжээчдийн дүгнэлтийг гаргаж, түүнийгээ тойрч энэ 126 ярьдаг байх явдал 1.1 дүгээр чухал, хамгийн гол асуудал.

Хоёрдугаар асуудалт орж ирсэн баялгаас орж ирсэн мөнгийг хэдэн луйварчин бүлэглэлийн гарт оруулчихгүйн тулд бид энэ дээр хяналтаа маш сайн тавих ёстой. Хяналт зарцуулалт гэдэг энэ хуулийн амин сүнс нь байгаасай гэж би хүсэж байгаа юм. Нарийн яривал Монголын ард түмэн арчаагүй хэдэн улс төрчдөөс болж 640 тэрбум долларын уул уурхайн курст суучихсан улсууд шүү дээ. Үнэгүй курс гэх нь хаашаа юм 640 тэрбум доллар. Оюу толгой өнөөдөр 242 сая төгрөг л төлсөн байгаа шүү дээ. Өчигдөр Булгантуяа гишүүн маш чухал мэдээллийг бидэнд өгсөн. ГОК гэхэд 224 тэрбум төгрөгийг хүүхдүүдэд энэ санд өгч байгаа.

Тэгэхлээр миний гол хэлэх гэж байгаа 2 зүйл бол бие даасан хөндлөнгийн шинжээчдийн дүгнэлтийг тойрч ярьж сурах ёстой. Нэгэнт баялгийн тухай ярьж байгаа бол.

Хоёрдугаарт, гарсан шийдвэр орж ирсэн баялгийг хяналт, хариуцлага тооцохдоо заавал ард иргэдтэй бид зөвлөлддөг, зөвшилцдөг, хяналтын механизм байх ёстой гэсэн энэ 2 зүйлийг энэ хуулийн үндсэн мөн чанар гэж би итгэдэг. Зарим хүмүүс гайхдаг Оюу толгой ч байна уу, уран гээд янз бүрийн зүйл дээр их юм асуух юм, эсэргүүцэж байна гэж бодож байна. Үгүй ээ нэг ч эсэргүүцсэн үг хэлээгүй. Ганцхан энэ зүйл нь яваасай, үр дүнтэй байгаасай. Сүүлд нь 15 жилийн дараа Оюу толгой шиг ингэж далаараа нэвт тавиулахгүйн тулд асуултуудаа сайн асуух ёстой, сайн хариулах ёстой, сайн унших ёстой бид. Тоо баримт, үндэслэлүүдийг нь сайн уншиж гаргаж байж энэ асуудлыг цааш нь явна. Монгол орон баялаг ихтэй. Баялагтайгаа яаж харьцах вэ гэдэг баялгийн хараалд очихгүйн

тулд бид өөрсдөө чамбайрч хариуцлагатай асуудалд хандах ёстой гэдэг ийм байр суурийг би илэрхийлье.

Д.Амарбаясгалан: Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хурал 10 орчим минутын дараа өндөрлөнө гэж байна. Тэгээд гишүүд танхимд орж ирэхээр санал хураалт явуулна. Агваанлуvsангийн Ундраа гишүүн Байнгын хорооны хуралд орсон байна уу?

Гишүүд асуулт авч, хариулт авч дууслаа.

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

16.52 цаг

Одоо Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулна.

Тэгье. Ирц бүртгэлийн санал хураалт явуулж үзье. Ирц бүртгэлийн санал хураалт.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаан дууслаа. Ингээд хэлэлцэж байгаа асуудлаар санал хураалт явуулахаар байгаа. Гишүүдийн ирц, бүртгэлийн санал хураалт явуулъя. Ирц бүртгэлийн санал хураалт.

Ирц бүртгэлийн санал хураалтад оролцож амжаагүй гишүүд гараа өргөө. Тоо аваадахъя. 13 гэдэг чинь тийм. Санал хураалт. Томьёолол танилцуулъя.

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулна.

Эцэслэн батлуулах хуулийн төслүүдийн хувилбарыг Эдийн засгийн байнгын хороо бэлтгэн гишүүдэд тараасан байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн бол хууль эцэслэн баталсанд тооцно гэж заасан байгаа.

Санал хураалт.

1.Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

74 гишүүн буюу 77.1 хувиар санал дэмжигдлээ.

Ням-Осорын Учрал сайд, Хэрлэн гишүүн, Чинбүрэн гишүүн нар дэмжсэнээр протоколд тэмдэглүүлье.

Хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

79 гишүүн буюу 81.4 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслүүд эцэслэн батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсэгт талархал дэвшүүлье. Дараагийн асуудалд оръё. Тэмүүлэн дарга.

16.55 цаг

Монгол Улсын Засгийн газар болон Монгол, Францын хамтарсан “Бадрах Энержи” ХХК-ийн хөрөнгө оруулагч Орано Майнинг С.А.С компани хооронд байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг зөвшилцөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

Төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Алтаншагай гишүүн үү? Алтаншагай гишүүн танилцуулна. Индэрт урьж байна.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Наранцэцэгийн Алтаншагай гишүүн танилцуулна.

Энэ Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу хөрөнгө оруулагчтай байгуулах хөрөнгө оруулалтын гэрээг зөвшилцөх дэгийн тухай хуулийн 8 дугаар зүйлд гэрээний төслийн агуулга, ач холбогдлыг харгалзан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо гишүүдийн олонхын саналаар гэрээний төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн зөвшилцөхөөр шийдвэрлэсэн байгаа.

Мөн хуулийн 9 дүгээр зүйлд, энэ хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо гэрээний төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн зөвшилцөхөөр шийдвэрлэсэн бол Улсын Их Хурлын тогтоолын төслийг санал, дүгнэлтийн хамт нэгдсэн хуралдаанд оруулна гэж хуульд заасан байна.

Мөн хуулийн 10 дугаар зүйлд Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн, Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын санал, дүгнэлтийг зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн бол энэ тухай санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлэнэ гэж бас хуульд бас тус тус заасан байна.

Ийм учраас Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны гишүүдийн олонхын саналаар чуулганы нэгдсэн хуралдаанаар уг тогтоолын төсөл орж ирж, хэлэлцүүлэхээр болж байгаа.

Ажлын хэсгийн нэрс наашаа өгье. Ажлын хэсэг танилцуулъя. Ням-Осорын Учрал Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Дорждэрэмийн Цолмон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Нармандахын Жамъянхүү Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Гүнчинсүрэнгийн Намчинсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга, Цэрэндоржийн Уранчимэг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлого зохицуулалтын газрын дарга, Баатарын Мөнхтогтох Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Салбарын хяналтын газрын дарга, Баасансүрэнгийн Алимаа Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Туулхангайн Ганбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хуулийн хэлтсийн дарга, Зэнээмядарийн Батбаяр Усны газрын дарга, Сэрээндоржийн Төгсжаргал Татварын ерөнхий газрын Том татвар төлөгчдийн газрын дарга, Бямбаагийн Болдбаатар Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга, Гун-Аажавын Манлайжав Цөмийн энергийн комиссын ажлын албаны дарга, Энхгэрэлийн Нямдаваа Цөмийн энергийн комиссын ажлын албаны Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга, Мавагийн Чадраабал Цөмийн энергийн комиссын ажлын албаны Цөмийн технологийн бодлогын газрын дарга, Сэр-Одын Ган-Очир Ашигт малтмал, газрын тосны Геологи ашиглалтын газрын дарга, Лхагвасүрэнгийн Жаргалсайхан Шинжлэх ухааны академийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн захирал, Бат-Эрдэнийн Хулан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх, Алтангэрэлийн Мандуул Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх, Цагааны Өнөрнасан Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Геологи, уул уурхайн Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч Санжаагийн Наранцогт “Эрдэнэс Монгол” компанийн гүйцэтгэх захирал, Лувсаншаравын Наранчимэг “Эрдэнэс Монгол” компанийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга, Балжиннямын Гэрлээ “Эрдэнэс Монгол” компанийн нэгдлийн Хууль, эрх зүйн зөвлөлийн дарга, Цэдэнбалжирын Төгсбуян “Эрдэнэс Монгол” компанийн Геологи, үйлдвэрлэлийн бодлогын газрын дарга, Түмэнжаргалын Төрбадрах “Эрдэнэс Монгол” компанийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга, Доржбалын Далайжаргал “Мон-Атом” компанийн захирал, Амарсайханы Алтанхундага “Мон-Атом” компанийн Уул уурхайн ахлах инженер, Дашдаваагийн Сугарсүрэн “Мон-Атом” компанийн Захиргааны удирдлагын албаны дарга, Лхагвын Өнөрбаатар “Эрдэнэс Оюу олгой” компанийн Геологи, уул уурхайн хэлтсийн ерөнхий менежер, Батцэнгэлийн Баяр-Өлзий “Эрдэнэс Оюу толгой” компанийн Санхүүгийн шинжилгээний хэлтсийн ерөнхий менежер, Цэрэндоржийн Мөнх-Оюунбаатар “Эрдэнэс Оюутолгой” компанийн Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Дашдоржийн Баярхүү Олон улсын харилцааны судлаач, профессор, Яндагийн Ганболд Монголын мал эмнэлгүүдийн дундын хоршооны зөвлөх, Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, академич, профессор, Норовын Тэгшбаяр Физикийн ухааны доктор, Ганбатын Мөнхболд Дотоодын хуулийн зөвлөх, Баярбатын Батмандах Дотоодын хуулийн зөвлөх, Зуунайн Шагдарсүрэн Дотоодын хуулийн зөвлөх, Сүхдоржийн Батхүлэг Дотоодын хуулийн зөвлөх.

Ингээд Наранцэцэгийн Алтаншагай гишүүнийг индэрт урьж байна. Байнгын хорооны санал, дүгнэлтийг танилцуулна.

Н.Алтаншагай: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр Монгол Улсын Их Хуралд зөвшилцөхөөр ирүүлсэн Монгол Улсын Засгийн газар болон Монгол Францын хамтарсан “Бадрах Энержи”, хөрөнгө оруулагч Орано Майнинг С.А.С компанийн хооронд байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2025 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасны дагуу Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд зөвшилцөхөөр ирүүлсэн дээрх асуудлыг хэлэлцэх хуралдааны дэгийн тухай хуульд зохицуулагдаагүй байсныг Монгол Улсын Их Хурлын 2025 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн чуулганы хуралдаанаар Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу хөрөнгө оруулагчидтай байгуулах хөрөнгө оруулалтын гэрээг зөвшилцөх дэгийн тухай хуулийг баталсан.

Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу хөрөнгө оруулагчтай байгуулах хөрөнгө оруулалтын гэрээг зөвшилцөх дэгийн тухай хуулийн 2 дугаар зүйлд заасны дагуу Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн, Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо гэрээний төслийг тус тус хуралдаанаар урьдчилан хэлэлцэж, санал, дүгнэлтийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд ирүүлснийг Байнгын хороог уг хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу нэгтгэн хэлэлцлээ.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанаар дээрх төслийг хэлэлцэх үеэр Улсын Их Хурлын гишүүн Алтаншагай асуулт асууж, гишүүд үг хэлээгүй болно.

Тус Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Монгол Улсын Засгийн газар болон Монгол Францын хамтарсан “Бадрах Энержи” ХХК Хөрөнгө оруулагч Орано Майнинг С.А.С компани хооронд байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний төслийг зөвшилцөхийг дэмжсэн болно.

Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу хөрөнгө оруулагчтай байгуулах хөрөнгө оруулалтын гэрээг зөвшилцөх дэгийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо гэрээний төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн зөвшилцөхөөр шийдвэрлэсэн бол Улсын Их Хурлын тогтоолын төслийг санал, дүгнэлтийн хамт нэгдсэн хуралдаанд оруулна гэсний дагуу Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн дэмжлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, дэмжиж өгөхийг та бүхнээс хүсье.

Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье.

Нийт 17 гишүүн нэрээ өглөө. 17 гишүүнээр тасаллаа. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

О.Номинчимэг: Баярлалаа. Энэ Орано ураны энэ хөрөнгө оруулалтын гэрээтэй холбоотой нэлээн нарийвчилсан хэлэлцээр хийсэн гэрээний төсөлтэй танилцсан. Тэгэхээр яг энэ Улсын Их Хуралтай зөвшилцөж байгаа үед цагт 3 асуудлыг бас анхаараасай, ажлын хэсэг анхаараад, хэрвээ дахиад зөвшилцөх дахиад negotiation хийх боломж гарвал, мөн засвар хийх боломж гарвал энийг бас анхаараасай гэж бодож байгаа учраас хэлье.

Нэгдүгээрт, энэ хуулийн биш, хөрөнгө оруулалтын гэрээний 4.3, 4.4-тэй холбоотой асуудал байна. 4.3 ямар ч байсан Монгол Улсын хууль тогтоомжид энэ үйл ажиллагаанд нь сөрөг нөлөө үзүүлэх юм гарах юм бол тусгай нөхцөлтэй тээ. Дахиад энэ хөрөнгө оруулалтын гэрээг бол 2 тал дахин хэлэлцэнэ гэж байгаа юм.

Тэгтэл 4.4 дээр бол Монгол Улсын хууль тогтоомжид хэрвээ одоо энэ хөрөнгө оруулалтын гэрээнээс илүү таатай нөхцөл үүсэх юм бол энэ зөвхөн татвартай, тогтворжуулж байгаа 4 төрлийн татвараас гадна бүхий л төрлийн хууль тогтоомжийн өөрчлөлтийг оруулсан байгаа юм эни ченж/any change/гээд. Тэгэх юм бол мэдээж энэ компани, прожект компани маань үүний дагуу байна гээд.

Хамгийн ноцтой нь 4.4.б. буюу хожим нь тэр таатай нөхцөл нь хүчин төгөлдөр бус болоод Монгол Улс хуулиа өөрчлөөд илүү юу гэдэг юм, чанга хуультай болох юм бол хүчингүй болсон хууль ч хамаагүй илүү өөрт нь таатай байх энэ хуулийг энэ компани, энэ хөрөнгө оруулалтын гэрээ энэ үйл ажиллагаанд сонгон хэрэглэж болно гэсэн ийм заалт орчихсон байгаа юм. Тэгэхээр энэ нэг утгаараа бол хөрөнгө оруулалтын гэрээнд орж байгаа манай Монгол Улсын хууль тогтоомж хүчингүй болсон ч гэсэн энэ компанид үйлчилнэ. Хууль тогтоомжийн хамгийн боломжит хэлбэрээр хүчингүй болсон хуулиа бараг тогтворжуулж өгч байгаа гэсэн заалт орсон байна. Тэгээд энэ бол ер нь энэ 4 төрлийн татвартай холбоотой, хөрөнгө оруулалтын энэ тогтворжуулалттай холбоотой гэхээс илүү Монгол Улсын бүхий л хууль, эрх зүйн орчны асуудал болоод байгаа юм.

Тэгэхээр энэ энэ бүх хууль, эрх зүйн орчноо ингэж хөрөнгө оруулагч талд ийм хүчингүй болсон таатай хуулийг ч гэсэн хэрэглүүлэх боломжийг олгож байгаа нь бол өөрөө бас байж болшгүй зүйл учраас үүнийг яагаад энэ асуудал дээр ер нь хэр нөгөө талтайгаа зөвшилцсэн юм бол? Ямар нөхцөлүүд дээр ийм юм яригдсан юм гэдгийг нэгдүгээрт тодруулъя.

Хоёрдугаарт тодруулах юм бол энэ вето райт/right/ буюу төрийн эзэмшлийн давуу эрх маань өөрөө вето буюу хориг тавих хэрэгтэй байгаа. Яах вэ тэгээд Компанийн тухай хуулиа хараад энэ чинь Монгол Улсын хуулийн дагуу явж байгаа. Гол гол асуудлууд дээр мэдээж вето райт/right/-аа тавьсан байна лээ. Гэхдээ манай Монгол Улсын Компанийн тухай хуулиар сонирхлын зөрчилтэй хэлцэл, томоохон хэлцлүүд, их хэмжээний хэлцлүүдийг тодорхой нөхцөл журмын дагуу компани өөрөө ТУЗ-өөрөө баталдаг, эсвэл хувьцаа эзэмшигчдийнхээ хурлаар баталдаг.

Тэгэхээр энэ дээр 2 хувьцаа эзэмшигчийн л асуудал байгаа. Нэг бол Монгол Улсын Засгийн газар цөмийн Мон-Атомаараа дамжуулж, нөгөө талд нь Орано. Тэгэхээр Орано компанийн хувьд өөрийнхөө афилиэт буюу холбоо, хамаарал бүхий этгээдтэй энэ төслийн үйл ажиллагаатай холбоотой томоохон хэлцэл хийвэл, эсвэл ашиг сонирхлын зөрчилтэй хэлцэл хийвэл энэ дээр энэ шийдвэрүүд яаж гарах вэ? Компанийн тухай хуулиараа байх юм бол нөгөө 90 хувийн хувьцаа

эзэмшигч маань, ТУЗ маань бүгдээрээ татгалзах болоод Монгол Улсын төлөөлж байгаа 1 ТУЗ-ийн гишүүдийн 1 шийдвэр гаргахаар болж байгаа юу? Энэ дээр асуудал дээр илүү ярилцаж байгаа асуудлууд байна уу? Энэ их хэмжээний хэлцэл болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг шийдэхэд Монгол Улсын энэ хориг тавих эрх вето райт/right/-д 1 ТУЗ-ийн гишүүн маань ямар үүрэгтэй оролцохоор та бүхэн төсөөлж байгаа вэ гэдэг хоёр дахь асуулт байна.

Гурав дахь асуулт. Энэ эрх шилжүүлэхтэй холбоотой асуудал байна.

Д.Амарбаясгалан: Номинчимэг гишүүний минут нэмж өгье.

О.Номинчимэг: Эрх шилжүүлэхтэй холбоотой асуудал бол 17.1-д байгаа. 17.2-т бас ченж оф контрол/change of control/ гээд эрх шилжүүлж байгаа. Тэгээд яг ерөнхий байдлаар орсон байгаа. Тэгэхээр энэ дээр ер нь 2 тал хэлэлцэж байх даа хэрвээ Орана компани Францын Засгийн газрын энэ оролцоотой энэ компани өөрийн хувь эзэмшлийн 90 хувиа бусад компанид, өөрийн холбоо хамаарал бүхий этгээдэд биш гуравдагч этгээдэд зарах гэж байгаа тохиолдолд ямар процессоор, ямар зөвшөөрөл авах талаар ер нь 2 тал хэлэлцэж байгаа юу? Яагаад гэвэл энэ хөрөнгө оруулалтын гэрээний бидний маш чухлаар тавьж байгаа юм энэ гуравдагч хөрштэй хийж байгаа хөрөнгө оруулалтын гэрээ. Мөн стратегийн орд дээрээ хийж байгаа гэрээ.

Тэгэхээр бид нар ямар хүнтэй хамтрах, хэр хугацаанд хамтрах гэдэг маань энэ төслийн хувьд маш чухал байгаа. Тэгэхээр энэ дээр “Орано” компанийн хувьд хувьцаа эзэмших асуудлаа шилжүүлэх асуудал дээр ямархуу процессоор явна гэдэг дээр талууд ямар нэгэн зөвшилцөлд хүрч байгаа юу гэж байгаа юм. Тэгээд дээр нь энэ гэрээ, хугацаа дуусаж байна дараа нь тодруулъя даа.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ням-Осорын Учрал.

Н.Учрал: Энэ хөрөнгө оруулалтын гэрээг хэлэлцээ хийхэд 5 дэд ажлын хэсэг ажилласан, 5 салбарын сайдаар удирдуулсан, Хууль зүй, дотоод хэргийн сайдаар удирдуулсан энэ гэрээ, эрх зүйн ажлын хэсэг ажилласан. Өнгөрсөн хугацаанд олон улсын хуулийн зөвлөх “White&Case” компанитай хамтын ажиллагаа бол намайг ч гэсэн ажлын хэсгээ ахлахаас өмнө энэ “White&Case”-тэй ажиллаж байсан. Тэгээд энэ “White&Case”-ээс өгсөн гол зөвлөмжүүдийг бол бид барьж ажилласан гэж хэлж болно. Тэгэхээр дотоодын хуулийн зөвлөхүүд бол бас орж ажилласан.

Тэгэхээр Монгол талын эрх ашгийг хамгаалах чиглэлээр манай хуульчид бас олон улсын түвшинд хэлэлцээ хийх бас өндөр чадамжтай болчихсон юм гэдгийг би хэд хэдэн зүйлээр харлаа. Энэ хэлэлцээний явцад тэр вето эрхийг албажуулж авах, хэлэлцээгээр тохирох тийм амар байгаагүй. Жишээ нь ТУЗ-д вето эрх байхгүй 3 хүн сууна уу, 4 хүн сууна уу ямар үр дүнд хүрдэг вэ гэдгийг Оюу толгойгоос харж болно. 3 хүн цалинжуулж байгаа болохоос биш тэр хүмүүс яг бодитоор хориг тавиад, асуудалд шууд хандаад, оролцоод, шийдвэрүүд дээр хориг тавиад явах ийм эрх байхгүй.

Тийм учраас энэ вето эрхтэй байгаагийн шалтгаан энэ хөрөнгө оруулалтын гэрээнд ч гэсэн хэрвээ тус компани зээл авна гээд шийдвэрлэх юм бол ТУЗ-өөр

ороход 100 хувийн хамтын шийдвэрээр заавал энэ шийдвэр гарна. Тэгэхээр 1 хүн татгалзахад авахгүй л гэсэн үг. Тэгэхээр одоогийн энэ Оюу толгой дээр үүсээд байгаа шиг ирээдүйд өр төлбөр үүсэхгүй гэсэн үг. Вето эрх бол дүрэмд өөрчлөлт орох, хувь хувьцаа шилжүүлэх, өөрчлөн байгуулах, татан буулгах, бүх асуудал дээр бол хориг тавих бүрэн эрхтэй Засгийн газрыг төлөөлж байгаа. Тэгэхээр энэ бол мэдээж давуу тал гэж би ерөнхий бас мэдээллийг өгье.

Мэдээж хууль буцааж хэрэглэхгүй гэдэг Монгол Улсын хууль тогтоомжийн ийм суурь зарчим байгаа. Хуулийг буцааж хэрэглэхгүй. Тэгэхээр бид энэ Би Ай Ти болон эрчим хүчний Ар Ти-гаар Монгол Улсын Иргэний хуулийн дагуу гэрээнээс тааламжтай нөхцөл байвал дагаж мөрдөх ийм олон улсын зарчмыг бол бас барьж ажилласан. Дээрээс нь бол бид нар энэ хөрөнгө оруулалтын гэрээний дараа хувь нийлүүлэгчдийн гэрээ хийнэ. Хувь нийлүүлэгчийн гэрээ хийхэд бид Монгол Улсын хуульд нийцүүлнэ гэсэн энэ зарчмаа бариад явна гэсэн ийм бол үг гэж бас ойлгож болно. Тэгэхээр энэ тэр эрх шилжүүлэх болон бусад асуудлууд дээр манай Хууль зүйн яамныхан дэд ажлын хэсгийнхэн бас нэмээд хариулах байх гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Ер нь Учрал сайд зээл авлаа гэхэд Монголын талын олох орлогод нөлөөлөх зүйл бол байхгүй шүү дээ. Тэрийгээ бас тодорхой хариулах нь зүйтэй байх гэж бодож байна.

Хууль зүйн яам Жамъянхүү Хууль зүйн бодлогын газрын дарга нэмж хариулъя. Ажлын хэсгийн 21 дүгээр микрофон.

Н.Жамъянхүү: Номинчимэг гишүүний асуултад хариулъя Хууль зүй, дотоод хэргийн Жамъянхүү.

Гэрээний төсөл дээр яах аргагүй энэ 4.3, 4.4 дээр бол гэрээ байгуулснаас, хүчин төгөлдөр болсноос хойш Монгол Улсын хууль тогтоомжийн өөрчлөлтөөр ялангуяа гэрээн дээр орсон нөхцөлүүдээс илүү тааламжтай, эсвэл сөрөг, хөрөнгө оруулагч талд тааламжтай, эсвэл сөрөг ийм нөлөө үзүүлсэн тохиолдолд бол энэ гэрээний заалтыг дагаж мөрдөх үү гэдэг ийм 2 зохицуулалтууд орсон. Ялангуяа 4.3 дээр бол энэ бид нар бас энэ тодорхой хэмжээний нөлөөллүүд нь материаллаг байдлаараа 5 хувьд хүрэх юм бол эргээд талууд бол хэлэлцэж, хэлэлцэх байдлаар бас энийг асуудлыг шийдэж болно.

4.4-д бол бас энэ тодорхой заалтууд орсон байгаа. Ялангуяа 4.4.1 дээр бол энэ гэрээний 4.3 дугаар зүйл үл харгалзан гээд төсөл хэрэгжүүлэгч компанид аливаа байдлаар таатай нөлөөлөх энэхүү гэрээнд зааснаас бага татварын хувь, хэмжээ болон үндсэн хөрөнгөд элэгдэл, хорогдол, тооцоолол шилжүүлэх хугацаа тогтоосон эсхүл төсөл хэрэгжүүлэгч компанийн гэрээнд заасны дагуу төлбөл зохих татварын хэмжээг ямар нэгэн байдлаар бууруулсныг оруулаад зөвхөн үүгээр хязгаарлагдахгүйгээр бас Монгол Улсын энэ хууль тогтоомжид орсон өөрчлөлтийн аливаа таатай нөхцөлийг бас эдлэх ийм боломж байгаа. Гэхдээ энэ талаар Засгийн газартай бас зөвшилцөх байдлаар, Засгийн газарт мэдэгдэх байдлаар төсөл дээр орсон байгаа. Эдгээр зарчмууд нь бол ялангуяа энэ Монгол Улсын Франц Улстай байгуулсан Би Ай Ти болон эрчим хүчний Ар Ти-гаар бол хэд хэдэн зарчмууд байдаг. Ялангуяа олон улсад хэрэглэгддэг үл ялгаварлах хөрөнгө оруулагчдыг хамгаалах. Янз бүрийн таатай болон сөрөг өөрчлөлтүүдийг бол бас тодорхой хэмжээгээр авч хэлэлцэх ийм зарчмууд байдаг. Энэ эд нарыг харгалзаж үзсэн.

Үүнээс гадна бол энэ гэрээн дээр бас бид нар эцэслэхдээ ялангуяа энэ 4.4.b.дээр Номинчимэг гишүүний бас саналуудыг бас харгалзаж үзээд бас эцэслэх дээрээ ярилцаж энийг бас нөгөө талтайгаа зөвшилцөж бас шийдвэрлэх ийм боломжтой байгаад байгаа юм.

Д.Амарбаясгалан: Сүхбат, Номинчимэг гишүүн тодруулж асууя.

О.Номинчимэг: 4.4.б. бол үнэхээр энэ бол олон улсын гэрээний эрх зүйн ерөөсөө стандарт зохицуулалт биш байхгүй юу. Энэ бол Монгол Улсын хүчин төгөлдөр байгаа хууль, эрх зүйн орчноос гадуур үйлчлэлийг л бий болгож байгаа гэсэн үг. Тэгэхээр үнэхээр та хэд дахиад хэлэлцээр хийх гэж байгаа бол яг энэнийхээ хүрээ хязгаарыг багасгах, эсвэл энэ заалтыг авч хаях тал дээр бас анхаараасай гэж хэлмээр байна.

Хоёрдугаарт энэ түрүүн бас хэлсэн гэрээ шилжүүлэх гэдэг ойлголт байгаа. Тэгээд энэ гэрээний болохоор 2 хэлтэй байгаа мэдээж. Ямар нэгэн дискриптив буюу өөр байх юм бол Англи хэлийг нь дагана гэж байгаа. Тэгэхээр энэ 17.1 дээр байгаа гэрээ шилжүүлэх буюу трансфер оф райтс/transfer of rights/19 дээр байгаа нөгөө асаймент оф райтс/assiment of rights/ гээд 2 ойлголтыг хоёуланг нь эрх шилжүүлэх гэдгээр байгаа байхгүй юу. Ер нь бол адилхан ойлголт. Гэхдээ энэ дээр Англи хэл дээрх нэр томъёогоо жигдэлж явахгүй бол дараа дараагийн хийх гэж байгаа гэрээнүүд дээр чинь өөр үр дагавар гарах учраас үүн дээр бас анхаараасай гэж бод.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Энэ бас энэ ажлын хэсгийнхэн анхаарч аваад, Тамгын газар бас анхаарах хэрэгтэй. Сая Даргын дэргэдэх зөвлөл дээр бас энэ Улсын Их Хурлын гишүүд хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой хэлж байгаа санал, зориуд бас протоколд тэмдэглүүлж байгаа үгсийг хэлэлцээрийнхээ явцад маш сайн анхаарч ажиллах ёстой. Бас Улсын Их Хурал дээр энэ гарсан саналуудыг авч, ажлын хэсгийн түвшинд ажилласан байдлыг эргээд дүгнэх асуудлыг бас ярьдаг болох ийм шаардлагатай байгаа. Тэгэхээр ганц энэ ажлын хэсэг биш ер нь бусад бүх ажлын хэсгийн түвшинд энэ Улсын Их Хурлын гишүүдийн Байнгын хороо, чуулганы хуралдаан дээр хэлсэн санал, зарчмын зөрүүтэй санал болон зориуд бас протоколд тэмдэглүүлж хэлсэн үгсийг харгалзан сайн үзэж байх ёстой шүү гэдгийг бас хэлье.

Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэбат: Гэрээний бас ажлын хэсэгт бас гэрээний нарийвчилсан заалтуудтай холбоотой бас хугацаа богино байгаа учраас. Ерөнхийдөө бүх заалтуудтай нь олон санал өгсөн боловчиг тодорхой саналуудаа өгсөн. Бас харьцангуй энэ хөдөлмөр, эрх, хүний эрхтэй холбоотой заалтууд маань жишиг болохуйцаар саналууд туссан. Гэхдээ анхаарах ёстой хэд хэдэн асуудал байна гэдгийг би бас тодруулж бас хэлье.

Нэгдүгээрт, энэ манай ер нь гадаадын томоохон энэ хөрөнгө оруулалтын төслүүд дээр нийгмийн үнэлгээний тайлан гэдэг энэ зүйлийг хийхгүй ингээд орхичоод байгаа юм. Энийг багцаар нь хийх ёстой. Зарим хэсгийг нь оруулж ирээд, зарим хэсгийг нь үлдээчхээд байдаг. Ялангуяа манай энэ Оюу толгой, Петрочайна гэх мэтчилэн зүйл 10, 20 жил бас болж байгаа. Энэ тухайн бүс нутаг

энэ уурхай нь ерөнхийдөө хээрийн нөхцөлтэй контейнерт амьдруулдаг, гэрт амьдруулдаг. Тэгээд энэ уул уурхай хаалтын 30, 40 жилийн дараа хаагаад явахад нь тэнд юу үлдэх вэ? Суурь нь тосгон үлдэх ёстой, стандарт хангасан орон сууцад хүмүүс нь ажиллаж амьдрах ёстой гэдэг ийм зүйлийг бас тавих ийм шаардлагатай. Тийм учраас би энэ дээр тодруулаад ер нь яг энэ ураны төсөл хэрэгжүүлж байгаа энэ орчинд ямархуу камп байдлаараа хүмүүс амьдарч ажиллах вэ энэ чинь гэдгийг нэгдүгээрт тодруулж асуумаар байна.

Дээрээс нь туслан гүйцэтгэгч компаниуд гээд бас нөхдүүд орж ирдэг. Үндсэн компанийн ерөнхийдөө энэ гэрээнийхээ дагуу тавьж байгаа боловчиг туслан гүйцэтгэгч компаниудад давхар энэ шаардлагуудаа тавьж өгөхгүй бол төсөл дотор орж ирж байгаа манай Монгол компаниуд ч орж ирдэг, өөр гадаадын компаниуд ч орж ирдэг. Тэр нөхдүүдэд хамаг будилаан байдаг шүү. Цалин нь 7-12 сая төгрөг гэж байгаа боловчиг туслан гүйцэтгэгч компани нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр ингээд явчихдаг. Тийм учраас энэ зүйлүүдээ тэр компани дээр яах вэ гэрээн дээр оруулсан ерөнхий утгаараа байна лээ. Бэлтгэн нийлүүлэгч компаниудад бол ийм шаардлагуудыг хангана, хүний эрхийн зүйлүүдийг хангана гэж байгаа гэдэг заалт байгаа боловч энийгээ тодруулж тавихгүй бол бас асуудал байдаг гэдгийг бас хэлмээр байна.

Учрал сайдаас тодруулж асууя. Энэ хэвлэлээр бас та ярьсан байх шиг байна лээ. Нийт төслийн хугацаанд ажиллах ажилтны 17 хувь уу, эс үгүй бол 17 хүн гэж байгаад байх шиг байна лээ. Тэгээд энэ тал дээр бас би тодруулаад асуучихъя гэж бодож байна. Тэгээд төслийн хувьд харьцангуй бас өгч байсан саналууд маань нэлээн хэд нь бас туссан цалин хөлсний хувьд, тэгээд эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй гэх мэтчилэн ийм зүйлүүдийг би туссан байгаа юм.

Тийм учраас саяын энэ зүйлүүд дээр би анхаарал хандуулж бас хандаасай. Дээрээс нь хамгийн сүүлд хэлэхэд цалингийн сангийн хувьд хэдийгээр цөөхөн гадаадын ажилчид гэж байгаа боловчиг нийт цалингийн сангийн монгол ажилчдын хүртэх хувь, хэмжээ маань 90 хувьд буюу түүнээс дээш хэмжээнд яг байж чадах уу гэдэг дээр би тодруулж асууя. Бусад талаар энэ гэрээ маань бас харьцангуй энэ хөдөлмөр эрхлэлт, хүний эрх талдаа боломжийн гэрээний төсөл дээр ажлын хэсгүүдэд маань бас оруулсан байна лээ.

Тэгээд энэ хэрэгжилтийн явцын тайлангуудаа гэдэг зүйлээ бас бид нар явцын дунд болон хаалтын үед энэ нийгмийн үнэлгээний тайлан, гэрээнүүдийг хянаж явах зүйл дээр их анхаараарай. Гэрээ байгуулах нэг өөр. Гэрээг хэрэгжүүлнэ гэдэг чинь явцдаа бас үл ойлголцох байдал оруулж ирээд, дахин дахин асуудал гарч ирээд, ажилчид, удирдлагын хооронд, орон нутгийн хүмүүсийн хооронд ийм зүйлүүд бас орж ирээд байдаг шүү. Тэгэхээр үүнийгээ анхнаасаа маш сайн яриад ойлголцоод тавьчихвал урт хугацаандаа тогтвортой, хэл ам гараад байхгүй болов уу гэж би бас би бодож байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: “Мон-Атом” компанийн захирал Далайжаргал ажлын хэсгийн 17 дугаар микрофон.

Д.Далайжаргал: Гишүүний асуултад хариулъя. Энэ төсөл хэрэгжих хугацаанд дэд бүтцийн 3 том ажлыг хийх юм. Төмөр зам, цахилгаан эрчим хүч, авто зам гэсэн ийм 3 том төсөл байх юм. Зүүнбаян төмөр замыг өргөтгөнө. Авто

зам нийтдээ 160км авто замыг барина. Тэрний дотор 60км нь засмал зам байна, бусад замууд нь бол туслах чанарын зам байна. Дээрээс нь 500 хүнтэй жижиг хэмжээний тосгон байгуулна. Тэр бол 500 хүн амьдрах эхний ээлжид тосгон байгуулах тийм. Эхний ээлжид тийм 3 том хөрөнгө, 4 том төслийн хөрөнгө оруулалтыг хийх юм. Тэр 17 гэдэг 17 хүн. Нийтдээ энэ чинь 1600 хүн ажиллахад 17 хүн л гадаадын хүн байна. 17 ширхэг хүн.

Д.Амарбаясгалан: Эрдэнэбат гишүүн хариулт авч болов уу? Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн? Алга байна.

Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Баярлалаа. Тэгээд би энэ зөвшилцөж байгаа асуудлыг бүрэн дэмжиж байгаа. Тэгэхдээ бид хэд бас хэлэлцээрийг, гэрээг хийхдээ бас анхаарах зайлшгүй зүйлүүдийг бас гишүүд маань хэлж байна. Бас нөгөө талтайгаа бас аль болохоор бас ойлголцох, дундын хувилбарт хүрэх талаасаа бас ажлын хэсэг маань бас анхаарна биз гэж бодож байгаа юм. Тэгээд энэ Монгол Улсад цаашдаа хөрөнгө оруулалтыг дуудаж оруулж ирэх, эргээд Монгол Улсад бас хөрөнгө оруулж болох юм байна гэдэг ерөнхийдөө том мессеж өгнө. Монгол Улс бас нийтлэг байдлаараа өнгөрсөн хугацаанд энэ уул уурхайн салбар дээрээ бас тодорхой хэмжээний улс төрч гэх үү олон нийтэд бас зөв мэдээлэл өгч яваагүйгээс болоод бас олон нийтийн дэмжлэгийг авахгүй байх ийм тохиолдлууд байгаа. Тэгэхээр энэ дээр бас Байнгын хороон дээр хэлж байсан шиг энэ төслийн ач холбогдол, үүнээс үүсэж байгаа үр дагавруудыг бас иргэд, олон нийтдээ бас маш олон сувгаар энгийн байдлаар хүргэхэд бас анхаараасай гэж хүсэж байгаа юм.

Тэгээд би яах вэ ажлын хэсгээс 2 асуулт асууя гэж бодож байгаа юм. Ер нь гадаад харилцааны талаас энэ төслийг хэрэгжүүлснээр ямар ач холбогдлууд ер нь цаашдаа бас үүсэх вэ гэдэг дээр бас яг энэ ажлын дэд хэсэгт бас олон талын төлөөллүүд байгаа учраас иргэд, олон нийтдээ өгөөч гэж хүсэж байгаа юм.

Нэгдсэн Үндэстний Байгууллага Аюулгүйн зөвлөлийн 5 улсын 1-тэй бид хэд бас гэрээнд орох гэж байна.

Хоёрдугаарт энэ дээрээсээ үүсдэг тэр янз янзын иргэд олон нийтийн дунд байдаг 2, 3 толгойтой хонь, ишиг, хурга гээд явдаг. Энэ зүйл байх уу? Энэ усны асуудал дээр бас Тэгшбаяр доктор бас яг олон нийтэд яг эргэлзээгүйгээр мэдээллээ өгөөч гэж хүсэж байна. Би бас чуулганы индэр дээрээс. Ер нь Учрал сайд аа би бас энэ дээр таныг анхаараасай гэж бодож байгаа энэ компанитай энэ асуудлыг хэлэлцэх гэж 27 жил явлаа, дунд нь ч бас янз янзын асуудлууд гарлаа. Манайхан бас энэ дээрээ эрх ашиг, ашиг сонирхол, авлигад орооцолдсон тохиолдлууд ч байдаг. Энэ бүх саад бэрхшээлүүд цаашдаа энэ гэрээний юунд нөлөөлөхгүй биз дээ? Энэ дээрээ маш энэ гэрээний төслийг хийхдээ бас анхаарч өгөөч гэдэг зүйлийг хүсмээр байгаа юм.

Тэгээд энэ хөрөнгө оруулалтыг цаашдаа Монголд дуудахад том сигнал болж байгаа ч гэсэн би бас нэг зүйлийг энэ ташрамд хэлэхээс өөр аргагүй байгаа юм. Тэгээд би Хууль зүйн сайд маань алга байна. Би нөхөрсгөөр хэлж байгаа юм. Яг энэ асуудалтай холбоогүй ч гэсэн сүүлийн үед хөрөнгө оруулагчдыг дандаа халтай байх шийдвэрүүдийг манай Хууль зүйн сайд үйлдлээрээ гаргаад байна. Ялангуяа Улсын бүртгэл дээр зөвлөхөө аваачиж тавиад, Хяналтын газрын

даргаараа тавьсан байгаа юм. Хяналтын газрын дарга нь үүрэг гүйцэтгэж байхдаа байгууллагын хувийн мэдээлэл дээр шууд өөрчлөлт оруулаад, байгууллагуудын дарга, цэргийг сольж байна шүү дээ. Энэ чинь өөрөө компанийн мэдээлэлд өөрчлөлт оруулаад хөрөнгө оруулагч өмчөө алдаж болох юм байна гэдэг сигналыг хүртэл Монгол Улсын хэмжээнд өгч болох үйлдэл байхгүй юу. Энийг анхаармаар байна.

Өнөөдөр гарч ирэнгүүтээ хууль тогтоомж бас тодорхой, тогтвортой байх юун дээр гарч ирээд л Захиргааны ерөнхий хуулийг даваад, Засгийн газар, шүүхийн урдур оронгуутаа баахан журмуудыг хүчингүй болголоо гээд ард иргэдэд бас төөрөгдүүлсэн мэдээлэл хийлээ. Үүний чинь цаана энэ ерөөсөө Монгол Улс чинь даргын орон юм байна, дарга нь гарч ирээд өөрт нь таалагдаагүй журмыг шууд хүчингүй гээд зарлачихдаг юм байна гээд ийм сигнал өгч байгаа байхгүй юу. Өөрөөр хэлэх юм бол бүрэн эрхэд нь хамаагүй ийм зүйлүүдээр үндсэндээ хууль, эрх зүйн орчныг тогтворгүй болгох, эргээд энэ өмч хөрөнгүүдийг нэг даргын үзэмжээр мэдээллүүдийг солиод авчихдаг юм байна гэдэг сигналуудыг Хууль зүй, дотоод хэргийн салбарын энэ Улсын бүртгэл өөрөө үйлдлээрээ гаргаад байгаагаа бас би анхаараач гэдгийг нөхөрсгөөр хэлж байгаа юм. Залуу хүмүүс байна. Өнөөдөр бас энэ ардчилал, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалж дуугарч байх ёстой хүмүүс маань ийм зүйлүүдийг том хөрөнгө оруулалтын гэрээтэй зэрэгцүүлээд үйлдлээрээ гаргаад байгаад бас харамсаж байгаа юм. Тэгээд ажлын хэсгээс Учрал сайд болон мэргэжлийн яг ажлын дэд хэсэгт орсон хүмүүс бас иргэд, олон нийтэд бас энэ мэдээллийг өгөөч гэж хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Дашдоржийн Баярхүү Олон улсын харилцааны судлаач, профессор. Ажлын хэсгийн 14 дүгээр микрофон.

Д.Баярхүү: Баярлалаа. Энэ Монгол, Францын энэ хамтын ажиллагаа энэ ураны салбарт орж ирж байгаа нь бол манай улсын хувьд бол гадаад бодлого, геополитик, геостратеги, гео эдийн засгийн онц ач холбогдолтой энэ дэлхий дахинд үлгэр жишээ болохоор ийм жишиг ийм хамтын ажиллагааны эхлэлийг тавих гэж байгаа юм. Тэгээд Франц хэн бэ гэхээр зэрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн Зөвлөлийн байнгын 5 гишүүний 1. Цөмийн зэвсэгтэй, цөмийн технологитой айл. Тэгэхлээр энэ Аюулгүйн зөвлөлийн байнгын 5 гишүүний 1 нь, хуучнаар капиталист ертөнцийн ийм хүчирхэг Франц улс анх удаагаа Монголд энэ хөрөнгө оруулалт хийхээр ингэж зориглож орж ирж байна гэдэг бол цаашдаа энэ Европын холбоонд ч, дэлхийд ч, баруун ертөнцөд бол маш том үлгэр жишээ болох ийм хамтын ажиллагааны эхлэлийг тавьж байгаа. Монгол Улсад бол тэр оруулах санхүүгийн ашиг тусаас илүү олон улсын харилцаанд Монгол Улс үнэхээр тоглогч байж чадах юм байна, итгэл хүлээж чадах юм байна. Европын Холбоонд, тэр дундаа Францын итгэлийг дааж байгаа юм бол Европын холбооны дараагийн 26 улсынх нь итгэлийг даагаад явах чадалтай юм байна гэж.

Тэгэхээр бол Франц өөрөө Европын холбооны бүүр л гол локимотив улс байгаа шүү дээ. Европын холбооны бодлогыг Франц, Герман 2 тодорхойлоод явж байдаг. Тэгэхээр Францтай ийм дотно хамтын ажиллагаанд орчих юм бол цаашдаадаа Монгол Улс энэ гуравдагч хөршийн хөрөнгө оруулалтыг татах бүрэн бололцоотой болж ирж байгаа юм. Тэгээд манай Гадаад бодлогын үзэл баримтлал, Аюулгүй байдлын үзэл баримтлалд чинь заачихсан байгаа шүү дээ гуравдагч хөршийн. Аль болохоор 2 хөршөөс гадуур, гуравдагч хөршийн хөрөнгө оруулалтыг татаж байж, эдийн засгийн сонирхлыг нь бий болгож байж Монгол

Улсын хөгжил дэвшил, аюулгүй байдлыг хангана гэсэн заалт байж байгаа шүү дээ. Тэр заалт ч гэсэн хэрэгжих бүрэн бололцоотой болж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Норовын Тэгшбаяр Физикийн ухааны доктор нэмж хариулт өгье. Ажлын хэсгийн 15 дугаар микрофон.

Н.Тэгшбаяр: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Физикийн ухааны доктор Норовын Тэгшбаяр байна.

Яг тэр олборлохуйц хэмжээний ураны нөөцтэй тэр давхаргын ус бол нэг талаасаа уран бол цацраг идэвхт элемент. Цацрахын хувьд хоруу чанартай. Нөгөө талаасаа химийн хувьд хоруу чанартай тийм давхарга байгаа. Тэр орчны усыг бол уран ашиглахаас өөр юунд ч ашиглах боломжгүй гэдгийг албан ёсоор хэлж байна. Ер нь энэ газар доор уусган баяжуулах аргаар дэлхий дээр 54-60 орчим хувь нь бол олборлож байгаа. Энэ бол дэлхийд туршигдсан ийм арга. Тийм учраас технологийн талаасаа ч асуудалгүй, тэр орчны усыг гаднаас юу гэдэг юм хүхэр хийгээд хордуулж байна гэж ойлгож ерөөсөө болохгүй. Жирийн хэллэгээр хэлэх юм бол хортой. Мэргэжлийн хэллэгээр хэлэх юм бол техникүүд хоруу чанартай. Тэр дээр юу ч хийсэн яг техникийн ус гарна. Ингээд энэ орчны усыг уран л олборлохоос өөр юунд ч ашиглах боломжгүй гэдгийг хэлэхийг хүсэж байна. Баярлалаа

Д.Амарбаясгалан: Ням-Осорын Учрал сайд нэмэлт хариулт өгье.

Н.Учрал: Энэ Сайнзориг гишүүн их чухал асуудлыг хөндөж байгаа. Энэ авлигын асуудал бол энэ гэрээг гацаасан гол шалтгаан. Яагаад гэхээр энэ 2015 оны манай энэ төрийн албан тушаалтнуудтай холбоотой хэрэг, маргаан олон улсын шүүх дээр очоод Францын шүүх шийдвэр гаргасан. Тэгээд ер нь үүнээс, энэ цагаас хойш авхуулаад энэ хөрөнгө оруулалтын гэрээ гацсан. Тэгээд ер нь л ийм авлига, ашиг сонирхлыг давж чаддаггүй. Тэгээд хэлэлцээ хийе гэхээр ингээд хувийн ашиг сонирхол ярьдаг. Ийм л хэлбэртэйгээр явсаар байгаад хөрөнгө оруулалтын олон гэрээг гацаасан юм билээ.

Тийм учраас бид энэ удаагийн гэрээн дээр хөрөнгө оруулалтын гэрээнд авлигын эсрэг бүлэг заалтыг оруулж өгсөн. Авлигаас урьдчилан сэргийлэх гээд. Энэ ФАТФ-ын зөвлөмжийг хориглолтуудыг авах, Засгийн газрын үүрэг, авлигаас урьдчилан сэргийлэх амлалтууд.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Учрал сайдад нэмэлт минут өгье.

Н.Учрал: Энэхүү гэрээгээр зохицуулсан эрх, үүрэгтэй хэрэгжүүлэхтэй холбоотой гэрээний аль нэг тал нөгөө талдаа дараах үйл ажиллагаа явуулах хориглох гээд ийм авлигын эсрэг бүлгийг оруулж өгсөн. Тэгэхээр энэ хөрөнгө оруулалтын гэрээ бол энэ хорин долоо, найман жилийн хугацаанд бол олон л юмыг тууллаа л даа. Гэхдээ тэр өмнөх хөрөнгө оруулалтын гэрээнээс хойш бол бас орчин цагт боловсрол эзэмшээд, олон улсын түвшинд хэлэлцээ хийдэг олон мэргэжилтэй экспертүүд төрөн гарчээ.

Тийм учраас монголчууд бас хэлэлцээний ширээнд суугаад Монголын талдаа ашигтай гэрээ хийж чаддаг юм гэдгийг бол харуулах гэж энэ манай ажлын хэсгийнхэн бол шөнө, оройгүй зүтгэлээ. Гол нь 51 хувиа хангуулах энэ

тохиролцоонд өөрсдийнхөө санхүүгийн схем дээр, өөрсдийнхөө хөрөнгө оруулалтын гэрээний драфт дээр тохирч чадсан. Тэгэхээр энэ нөхдүүд, энэ манай ажлын хэсгийнхэн бол ямар нэгэн ашиг сонирхол, элдэв зүйлээс хол, яг л улс эх орныхоо нийтлэг эрх ашгийн төлөө зүтгэсэнд би бас талархаж байгаагаа илэрхийлье.

Д.Амарбаясгалан: Яндагийн Ганболд Монголын мал эмнэлгүүдийн дундын хоршооны зөвлөх, Монгол Улсын шинжлэх ухааны гавьяа зүтгэлтэн, академич, профессор хариулт өгье. Ажлын хэсгийн 21 дүгээр микрофон.

Б.Болдбаатар: Сая андуурагдчих шиг боллоо. Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга Болдбаатар. Сайнзориг гишүүний асуултад хариулъя.

Монгол Улсын Засгийн газраас 2012, 2020 онд тухайн бүс нутгийн хүн, мал, амьтны эрүүл мэндийн нөхцөл байдалтай уялдуулан 2 удаагийн том ажлын хэсэг томилогдож ажилласан байдаг. Дээж, сорьц авч шинжилгээнд тандалт хийж энэ бүхнийг судалсан. Яг 2 ажлын хэсгийн эцсийн дүгнэлтээр уранаас шалтгаалж тухайн бүс нутагт ургийн гажилттай мал дээр төрөлт үүссэн гэдэг нь бол нотлогдоогүй. Албан ёсоор тогтоогдоогүй.

Гэхдээ хөрөнгө оруулалтын гэрээнд 8.1 дээр нь ашиглалт эхлэхээс өмнө тухайн бүс нутгийн мал, амьтны эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээг хийж, тайлан гаргаж баталгаажуулсан байна гэдэг 1 дүгээр заалт орсон.

Хоёрдугаарт урт хугацааны болзошгүй эрсдэлээс сэргийлж, хэрэв нөлөөллийн үнэлгээний дүгнэлтээр тухайн бүс нутагт эрсдэлтэй, өртөмтгий гэж үзэх юм бол малгүй бүс бий болгож, тухайн бүс нутгаас малыг нь чөлөөлсний төлөө малчдад нөхөн олговор олгох асуудлыг Францын хөрөнгө оруулагчийн тал хариуцахаар хамтын ажиллагаа гэсэн 11.1 дэх хэсэг дээр нэмэлт гэрээний нэмэлт дээр оруулсан байгаа.

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Сайнзориг гишүүн тодруулж асууя.

П.Сайнзориг: Баярлалаа хариултууд өгсөнд. Тэгээд түрүүн бас Номинчимэг гишүүний хөндөж байгаа асуудлыг манай ажлын хэсэг анхаарна биз. Хууль, эрх зүйн орчны тогтворжуулалтыг эндээс хассан ч Иргэний хуулийнхаа 5.1-ээрээ Иргэний хууль тогтоомжийг буцаан хэрэглэх гээд энэ хувийн эрх зүйн харилцаан дээр угаасаа үйлчилнэ. Бид хэд энэ дээр их шийддэггүй юм шийдэж байгаа юм шиг хууль, эрх зүйн орчныг хэт тогтворжуулчихлаа энэ тэр гээд юм ярьж байна лээ. Тэгэхдээ энэ зарчмыг болж өгвөл Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт болон Цэцийн шийдвэрээр тухайн хуульд Үндсэн хуулийн цэцийн шийдвэрээр хуульд өөрчлөлт орсон бол тэр хэсэг нь хамаарахгүй байдлаар бас зарчмыг тогтоогоод явчихмаар байгаа юм. Үнэхээр Үндсэн хууль давсан, Үндсэн хуулийн том өөрчлөлт явчихаад байхад тэрийг тогтворжуулах, тэрнээс өмнөхийг тогтворжуулна гээд бас дайраад байж ерөөсөө болохгүй.

Тэгэхээр ер нь энэ гэрээн дээр туссан ч бай, тусаагүй бай Иргэний хуулийнхаа 5.1 дүгээр зарчим буюу хууль буцаан хэрэглэх зарчим ийм хувийн эрх зүйн хөрөнгө оруулалтын гэрээн дээр үйлчилдэг юм. Манайхан энийгээ бас зөв

ойлгохгүй Францын талд л бүх зүйлийг нэг ийм тааламжтай байдлаар тавиад өгөх гэж байгаа юм шиг тийм мессежнүүдийг.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн асуулт асууя.

Д.Үүрийнтуяа: Та бүхэндээ оройн мэнд хүргэе. Надад 3 асуулт байна.

Нэгдүгээрт, бүтээгдэхүүний борлуулалтын үнийг тогтоох заалт дээр уран ислийн олон улсын спот зах зээлийн үнээс маркетингийн зардлыг хасаж тооцно гэсэн байна л даа. Тэгээд энэ маркетингийн зардал бол үйл ажиллагааны зардлын нэг хэсэг. Яагаад заавал зах зээлийн үнээс хасаж, тэгээд тэрийгээ тогтмол 2 хувь байхаар тооцож оруулж ирж байгаа юм бол? Эргээд нөгөө Засгийн газрын өгөөж, мөн хөрөнгө оруулагч талын өгөөжийг харахаар өгөөжийн задаргаа дотроо энэ маркетингийн төлбөр нь нөгөө талдаа өгөөж болж орж ирээд байх юм. Яагаад өгөөж гэж үзээд байгаа юм бол? Ер нь энэ маркетингийн төлбөр, ноу хау энэ төлбөр нь бол татварын үнийг, татвар тооцох тэр борлуулалтын үнэд нөлөөлөхгүй гэж заасан байгаа. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс тооцохдоо хасаагүй дүнгээр тооцох юм байна. Харин энэ борлуулалтын орлогоос хамаардаг, борлуулалтын орлогоос тооцдог татвар үйл ажиллагааны ашигт нөлөөлнө энэ мэдээж. Тэгэхээр ашгаас тооцох тэр татварууд мөн ноогдол ашиг дээр үүний зөрүүг яаж тооцож оруулахаар гаргаж байгаа юм болоо? Тооцож байгаа юм бол оо?

Хоёрдугаарт, Засгийн газрын өгөөж, хүртэх өгөөж дотор ажил олгогчоос төлөх НДШ-ийг яагаад Засгийн газрын өгөөж гэж тооцсон юм бол? Энэ бол даатгуулагчийн, уг нь бол Нийгмийн даатгалын сан зарчмаараа энэ төсвийн орлогын бүрдүүлбэр, агуулгаар биш юм шүү дээ. Даатгал гэдэг чинь уг нь сайн дурынх байх ёстой. Манай тогтолцоо л өөрөө энийг төсвийн орлогын нэг хэсэг болгож яваад байгаа. Магадгүй энэ ирэх хаврын чуулганаар өөрчлөгдөх хуулиуд дээр энэ тодорхой өөрчлөлтүүд орох байх гэж бодож байгаа. Яагаад энэ заавал Засгийн газрын өгөөж болж орж ирээд байгаа юм бол?

Гуравт нь Засгийн газрын нийт хуримтлагдсан өгөөжийг тооцохдоо шууд өгөөжийг хуримтлалыг нь тооцохдоо төслийн нийт өгөөжөөс анхны хөрөнгө оруулалтын 500 сая долларыг хасаад тэгээд нийт хуримтлагдсан Засгийн газрын өгөөжид хуваагаад энэ Засгийн газрын өгөөжийг тооцно гэсэн аргачлалыг гаргасан байна. Энэ аргачлал яагаад анхны хөрөнгө оруулалтыг хасаж тооцож байгаа юм бол гэсэн ийм 3 асуулт байна.

Д.Амарбаясгалан: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ням-Осорын Учрал хариулт өгье.

Н.Учрал: Энэ хөрөнгө оруулалтын гэрээг хийхдээ бид, анх бол Нямбаатар сайдын ахалж байсан үед, энэ Сайнзориг гишүүн тухайн үед ажиллаж байх үед энэ давуу эрхийн 10, тэр төрийн эзэмшлийн 34 хувийг орлуулах тохироог бас анх хийгээд, дараа нь Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр Амарбаясгалан даргыг ажиллаж байхад энэ протокол зурагдсан. Тухайн үед тусгай АМНАТ-ын дээд босго 5 байсан. Өнөөдөр бид нар Үндэсний баялгийн сан, Ашигт малтмалын хуулийг баталснаараа босгыг авч хаясан. Ингэснээрээ ер нь Монголын талд энэ орлуулснаараа яг Үндсэн хуулийн 6.2-ыг хангах уу гэдэг ийм суурь зарчмын төлөө л бид нар хэлэлцээ хийлээ гэсэн үг шүү дээ. Нэг босго нь байсан. Тэр босгыг яаж

давах вэ гэдэг ийм зарчмаа барихын тулд санхүүгийн модель гаргасан өөрсдийнхөө.

Тэгээд санхүүгийн модель дээр бол 77 байхад, 80 байхад, 90 байхад гээд ингээд ураны 1 фунтийн үнэ дээр тооцооллуудыг хийсэн. Ингээд тооцооллуудыг хийгээд үзэхээр яг 51 хангуулж байна уу гэдэг дээр л асуудлыг ярих болж байгаа. Тэгээд юун дээр яригдаж эхэлсэн бэ гэхээр яг Засгийн газрын үр өгөөж гэж аль аль төлбөр, татварыг тооцох юм, хөрөнгө оруулагчийн өгөөж гэж аль төлбөр, татваруудыг тооцох юм бэ гээд яригдсан. Тэгэхээр яг одоо энэ гишүүдийн ярьж байгаа ноу хау, маркетингийн зардлын асуудал бол зайлшгүй яригдаж байсан. Бид нар энийг хэлэлцээрийн явцад ярихад ноу хау-ыг бол дэлхийн зах зээл дээр зарагддаг, тэгээд хамгийн сүүлийн тэр кальцинатжуулах технологийн ноу хау-г энэ Орано компани эзэмшдэг юм байна. Оюуны өмч.

Тэгээд энэ ноу хауг Орано эзэмшдэгийг бид нар зөвшөөрөхгүй гэдэг ийм хэлэлцээрийг хийгээд тэгээд сүүлд тохиролцооноор юу вэ гэхээр Монгол талд бол энэ олон улсын санхүүгийн зөвлөмж өгөөд энийг хөрөнгө оруулагчийн өгөөжид тооцож байгаа гэдэг ийм саналыг бид нар тавьсан. Ингээд хэлэлцээ амжилттай болоод хөрөнгө оруулагч талын өгөөжид тооцоод буюу хөрөнгө оруулагч нар ноогдол ашгаараа, маркетинг ноу хау-ны төлбөрөөр л өгөөж авна. Тэгэхээр үндсэн зардал дээр бүртгэгдэхгүй гэсэн үг. Үндсэн зардал дээр бүртгэгдэхгүй гэдэг бол Монголын талд ялалт. Одоо Оюу толгой бол яаж байна гэхээр үндсэн зардал дээрээ бүртгээд яваад байдаг.

Тэгэхээр зардлаа авах болтол нэмээд л байдаг, нэмээд л байдаг ноогдол ашиг гарч өгдөггүй. Ноогдол ашгийн хугацаа хойшилдог. Одоо энэ тохиолдолд яах вэ гэхээр үндсэн зардалд нь бичээгүй учраас хөрөнгө оруулагч тал өгөөжид тооцсон учраас Ноу хау-ын төлбөр өндөр болоод байвал нөгөө талдаа буюу Монголын тал Засгийн газрын талд бол энэ чинь нөгөө 49, 51 гээд 2 тал байгаа учраас. Хэрвээ 49 талдаа хэрвээ тэр тал нь өсөөд байвал нөгөө талдаа ямар нэгэн байдлаар тийм импакт өгөөд эхлэхээр тэр чинь манай талд бас өсөөд эхлэхээр нөгөө өгөөж тохируулах буюу 51 хүрэхгүй бол өгөөж тохируулах зардал нь дахиад нэмэгдэх байхгүй юу. Тэгэхээр ер нь бид энэ гэрээн дээр өгөөж тохируулах буюу 51 хүрэхгүй бол өгөөжийн тохируулгын төлбөрийг авах заалтыг хийж өгсөн нь л энэ гэрээний хамгийн жишиг болсон зүйл. Тэгэхээр аль талдаа Вин вин/Win win/ байх зарчим хангагдаж байгаа юм л гэж ингэж ойлгож болно. Ажлын хэсгээс хариулъя.

Д.Амарбаясгалан: Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга. Ажлын хэсгийн 20 дугаар микрофон.

Б.Тэлмүүн: Сангийн яам Тэлмүүн асуултад хариулъя.

Маркетингийн төлбөртэй холбоотой асуудал бол хэлэлцээрийн явцад бид нарын хувьд хамгийн чухал асуудал байсан. Бид нар өмнөх сургамжтай холбоотой татвараас зайлсхийн эсрэг энэ асуудлуудтай холбоотой гол асуудал байсан. Энэ дээр бид 3 Үндсэн асуудлаар айлын талыг зөвшөөрүүлж чадсан.

Нэгдүгээрт, маркетингийн төлбөр бол ямар нэгэн байдлаар татварын зорилгоор бид нар юу ч тогтворжуулахгүй, яг олон улсын зарчмын дагуу бодит үнэ

тодорхойлох зарчмаараа, BEPS-ийн зарчмын дагуу тухай бүрдээ татварын албан тайлангаа тайлагнаад явна гээд нэгдүгээрт.

Хоёрдугаарт, маркетингийн төлбөр бол энэ Монгол Улсын энэ төсөл хэрэгжүүлэгч компаниас мөнгөн хөрөнгөөр гарах зардал огт биш. Энэ дэлхийн зах зээлийн үнээс марк ап буюу хасагдаж орж ирж гэрээ байгуулах үнэ байгаа. Тэгэхээр энэ яг “Бадрах Энержи” төслийн компаниас мөнгөн хөрөнгөөр гарах зардал огт биш. Энэ.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Нэмэлт минут өгье. Гүйцээж хариулъя.

Б.Тэлмүүн: Маркетингийн төлбөрийг бид ингэж тусгаснаар өмнөх Оюу толгой нь ч байдаг юм уу бусад уулархаг компаниудад байдаг жишгээсээ нэг давуу талыг олж байгаа нь дэлхийн зах зээлийн эцсийн үнээс бид борлуулах үнийг нь ингэж тогтоож өгч чадаж байгаа. Ингэснээрээ төсөл хэрэгжүүлэгч компани, толгой компанидаа ямар нэгэн байдлаар бага үнээр юм уу, өндөр үнээр гэрээгээ хийхгүй яг дэлхийн зах зээлийн үнэтэй уялдсан байдлаар ингэж асуудал яригдана.

Гурав дахь асуудал нь энэ маркетингийн төлбөрийг Учрал сайдын хэлснээр айлын талын өгөөж тооцно. Тэгэхээр борлуулалтын үнийг өсгөх юм уу, бууруулах замаар маркетингийн төлбөрөөр дамжуулан шууд бусаар өгөөж хүртэх энэ боломж хаагдсан гэсэн үг. Ийм байдлаар бид өмнө байгуулж байсан гэрээнүүдийн сургамжийг сайжруулан өөрийн талын саналаараа гэрээндээ тусгуулж чадсан байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Үүрийнтуяа гишүүн тодруулж асууя.

Д.Үүрийнтуяа: Ер нь бол нөү хау ойлгож байна. Маркетингийн зардлаа яг энэ өгөөж тохируулах хэсэг дээр ашиглаж байгаа гэж тайлбарлаад байгааг бас сайн ойлгохгүй л байна. Өгөөж тохируулах заалт орж ирсэн нь их давуу талтай. Энэ давуу талтай заалт. Гэхдээ 2 хувь гээд хязгаарлаад өгчхөж байгаа шүү дээ. Магадгүй Учрал сайдын тайлбарлаж байгаа шиг Оюу толгойн жишээг давтахгүйн тулд бид нар зардлыг хязгаарлаад 2 хувиас хэтрэхгүй гээд оруулчхаж бас болно. Олон улсын жишгийг харахад маркетингийн зардал 1-1.5 хувьтай явж байгаа. 1-1.5 хувьтай.

Тэгэхээр энэ маркетингийн зардал дээр бид нар борлуулалтын орлогоосоо бууруулаад л хасчхаж байгаа хэлбэр шүү дээ үндсэндээ. Үнээс хасчхаж байна гэдэг бол зах зээлийн үнээс хасаж байна гэдэг бол борлуулалтын орлогоос бууруулчхаж байгаа. Мөнгөн урсгалаар зардал гарахгүй ч гэсэн мөнгөн урсгалын орлогоо багасгачхаж л байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг та хэд маань бас анхаарч авч үзээсэй гэж хүсэж байна. Тэгээд энэ зарчмын хувьд.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Энх-Амгалан Эдийн Засаг, хөгжлийн яам. Ажлын хэсгийн 18 дугаар микрофон.

Л.Энх-Амгалан: Эдийн засаг, хөгжлийн яам Энх-Амгалан. Гишүүний асуултад хариулъя.

Өгөөжтэй холбоотой нийт өгөөжийн 51 хувь нь Монголын талд хуваарилагдахтай холбоотой хэлэлцээ нэлээн удаан үргэлжилсэн. Айлын талаас

тэр олборлох үйлдвэрийн ил тод байдлын тайланд байдаг бүх л Монголд орж байгаа, Монголд гарч байгаа зардлуудыг Монголын талын өгөөж гэж үзнэ гэдэг байр суурьтай байсан. Манай талаас зөвхөн татваруудыг төлбөр хураамжийг оруулахгүйгээр гэж, зөвхөн татваруудыг манай өгөөж гэж үзнэ гээд 2 талаасаа хэлэлцээ хийгээд жил гаран суусан. Тэгээд харилцан буулт хийсэн. Манай талаас сүүлдээ зөвхөн зардлын шинжтэй, улсад орж байгаа зардлын шинжтэй тэр татвар, хураамжуудыг өгөөж гэж үзэхгүй гэдэг дээр хатуу байр суурь илэрхийлж байж айлын тал хүлээн зөвшөөрсөн.

Д.Амарбаясгалан: 1 нэмж минут өгье.

Л.Энх-Амгалан: Агаарын бохирдлын төлбөр, тэр хог хаягдлын төлбөр, ус бохирдуулсны төлбөр гээд энэ бохирдол, зам ашигласны төлбөр энэ тэр гээд зарлалын шинжтэй бүх төлбөр хураамжуудыг Монголын талд мөнгөөрөө орж ирж байгаа ч гэсэн өгөөжид тооцохгүй гэдэг дээр айлын талтай тохиролцсон.

НДШ-ийн хувьд ажилтнаас төлж байгаа НДШ өгөөжид орохгүй. Зөвхөн ажил олгогчоос төлж байгаа нийгмийн даатгал өгөөжид орж байгаа. Энэ төсөл хэрэгжээгүй тэр бол тэр түвшний ажил олгогчид бэлтгэгдэхгүй, тэр түвшний НДШ төлөгдөхгүй байсан гэдэг агуулгаар л өгөөжид оруулахаас өөр аргагүй болж хувирсан.

Нөгөө талдаа энийг манайх өгөөжид оруулах юм бол айлын талыг маркетингийн төлбөрийгөө өгөөждөө оруул гэдэг ийм л хэлэлцээ болсон. Тэгээд айлын талд мөн маркетингийн төлбөрөө өгөөждөө оруулж авч байгаа ийм л эцсийн дүгнэлт дээр очсон доо.

Д.Амарбаясгалан: Отгоны Саранчулуун гишүүн асуулт асууя.

О.Саранчулуун: Юуны өмнө эдийн засгийн хувьд үр нөлөөтэй ийм том төсөл хэрэгжиж орон нутгийн оролцоог хангах талаар бас гэрээнд тусгасан байгаад талархаж байна. Төслийг энэ дэмжиж байна. Гэхдээ илүү сайжруулахын тулд хэдэн санал байна л даа. 2020-23 онд уул уурхайн салбарт 46 хүн үйлдвэрлэлийн осол, гэмтлээс болж нас барсан. 117 хүн хүнд болон хөнгөн гэмтэл авсан байгаа. Тэгэхээр тэдний хэд нь өнөөдөр хөгжлийн бэрхшээлтэй болсон бэ гээд амьдралынх нь юмыг үзвэл бас их тоо гарч ирнэ. Уул уурхайн үйл ажиллагаа өөрөө эрсдэл өндөртэй ийм салбарт гэж тооцогддог. Тэгэхээр энэ дээр бид нар хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын талаарх асуудлуудыг бас гэрээний төсөлд илүү тод томруун тусгавал илүү хэрэгтэй байна гэсэн ийм санал өгөх гээд байгаа юм.

Тэгээд 8 дугаар хэсэгт жишээлбэл, байгаль орчин, эрүүл ахуй, үйл ажиллагаа гээд хэрвээ хүний эрүүл мэндэд хор хөнөөл учирвал байгаль орчных нь зохицуулалтаар л шийднэ гэхихсэн байгаа юм. Тэгэхээр энэ хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг байгаль орчин хоёрыг тусад нь хууль, эрх зүйн хувьд хариуцлагатай нь салгаж ийм томъёолохгүй юм уу? Яагаад гэвэл энэ чинь 1600 гаруй хүн ажилд авах ийм том төсөл байгаад байна шүү дээ. Тэгэхээр энийг тус нь тодорхойлж томъёолмоор байгаа гэсэн үг.

Дээрээс нь 12 дээр хөдөлмөр эрхлэлт, сургалт гэхихсэн байгаа. Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй гэдэг чинь

хөдөлмөр эрхлэлтийн сургалт, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын сургалт гээд тэс өөр ойлголтууд байгаа байхгүй юу. Сургалтууд нь тусдаа байдаг гэдгийг бас дахиж ажлын хэсэгт анхааруулж хэлмээр байгаа.

Тэгээд 12.1.а. заалтыг харахаар хэрвээ төсөл хэрэгжүүлэгч компани энэхүү бүлэгтэй хамаарах аливаа харил харилцааг Монгол Улсын Хөдөлмөрийн хууль тогтоомж болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжоор зохицуулна гээд заачихвал энэ асуудал шийдэгдчихээр илүү тодорхой тусгачихаар юм болов уу гэж бодсон ийм саналууд байгаа байхгүй юу.

Яагаад гэхлээр манай Хөдөлмөрийн тухай хууль дээр 3.2-т хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйтай харилцааг зөвхөн тэр хуулиар дагнан зохицуулна гэсэн ийм заалт байдаг. Тэгэхээр энэ дээр ажлын хэсэг анхаараарай цаашдаа гэдэг ийм саналыг хэлж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ.

Жаргалсайханы Золжаргал гишүүн асуулт асууж, үг хэлье.

Ж.Золжаргал: 4 асуулт байна. Үүрийнтуяа гишүүний асуудаг тэр бас их чухал пойнт/point/ байсан. Энэ ураны шар нунтаг их тийм стратегийн чухал бүтээгдэхүүн, их айхтар олон нийлүүлэгчтэй тийм өрсөлдөөнтэй маркетинг хийгээд байдаг юм зах зээл биш гэж бодож байгаа. Тэгээд 2 хувийг ингээд борлуулалтаас нь маркетингийн зардал гэдэг чинь үндсэндээ нөгөө талдаа рояалти төлчхөж байгаа байдал болчхож байгаа байхгүй юу. Бид нар хуульдаа өөрчлөлт оруулаад маш их ярьж байж 5 хувиар 34 хувиа эзэмшлээс татгалзаад, 5 хувиар нөөцийн төлбөрөө нэмэх асуудал ярьсан. Нөгөө талдаа ингээд 2 хувийн рояалти шиг юм тавьчихаж байгаа юм. Тэгээд 5-аас хасах нь 2 ойролцоогоор шүү. Тэгэхээр чинь нөгөө 5 хувиар нэмсэн биш 3 хувиар нэмсэн юм шиг болоод дүн нь ингээд тулчхаж байна. Тэгэхээр асуулт нь бол энэ чинь тэгээд энийг ингэж зөвшөөрөхөөс өөр аргагүй байсан юм уу? Рояалти төлчхөж байгаа л хэлбэр гэж би харж байна. Олон улсын жишиг энэ дээр ямар байна вэ энэ? Аль улсын ямар гэрээн дээр жишээ байна вэ?

Хоёрдугаар асуулт нь НӨАТ тогтворжуулах татварын жагсаалтад байгаа. Тэгэхээр НӨАТ бол тогтворжчихно. Гэхдээ энэ гэрээний 5.8 дээр байсан нөгөө Засгийн газрын НӨАТ-аас чөлөөлөх жагсаалт дотор тэр жагсаалтыг мөрдөнө гээд Учрал сайдын хэд хоногийн өмнө ярьсан хариулт дээр тэр жагсаалт дээр бид нар шар нунтгийг эцсийн бүтээгдэхүүн гэж үзэхгүй. Бусад уурхайн төслүүдтэй үл ялгаварлах зарчмаар тохиргоо хийчих юм бол нөгөө тал хүлээж авна гэж байгаа юм. Гэтэл нөгөө талдаа энэ чинь тогтворжуулах татварт орчихсон байгаа. Тэгэхээр гэрээ байгуулахаасаа өмнө энэ өөрчлөлтийг хийнэ гэсэн ийм хүлээлт байна уу гэсэн асуулт байна. Яагаад гэвэл дараа нь тогтворжчихож байгаа учраас тээ?

Гуравдугаар асуулт нь элементийн хүхрийг дотоодоос худалдаж авахад түлхүү нэн тэргүүнд анхаарна гэсэн би тэгж уншлаа. Элементийн хүхрээс гадна хүхрийн хүчил биш бил үү? Эрдэнэтийн хэрвээ нөгөө хайлуулах үйлдвэр орох юм бол энэ хамгийн түгээмэл технологиор яг хүхрийн хүчил гарна шүү дээ. Тэгээд тэр нь дотоодын зах зээл уран дээр бий болж байгаа бол хоорондоо их сайхан уялдана. Манайд ч хэрэгтэй. Хүхрийн хүчил хаях боломжгүй учраас элементийн хүхэр гаргачихъя яах вэ гээд аягүй хүнд даалгавартай төслийнхөн бол ажиллаад

байгаа юм. Тэгэхээр энэ элементийн хүхэр юм уу, элемент хүхрийн хүчил юм уу? Аль аль нь байх ёстой байх.

Дөрөв дэх нь болохоор яа 12.3 дээр гэрээ нь инновацын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ гээд. Тэгээд уурхайн үйл ажиллагаа эхэлснээс хойш 5 жилийн дараа энэ ураны ашиглалт юм уу, цөмийн эрчим хүчний чиглэлээр инновацын хөтөлбөрийг боловсруулна, орон нутгийн боловсролын байгууллагатай хамтарна гэсэн байна. 5 жил байх тийм ямар хэрэгцээ шаардлага байдаг юм болоо? Уурхай ажиллалаа 1 жил боллоо, 2 жил боллоо. Зүгээр л хөтөлбөр боловсруулах гээд байна шүү дээ. Тэгээд орон нутаг гэдэг нь орчуулгын алдаа байна уу? Эсвэл энэ аймгийн боловсролын байгууллагатай хамтарч цөмийн энерги ураны инновац хийхгүй байлгүй дээ гэдгийг тодруулж асууя. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ням-Осорын Учрал хариулт өгье. Нэмж Тэгшбаяр доктор.

Н.Учрал: Энэ бол хэлэлцээ. Тэгэхээр хэлэлцээ бол мэдээж нэг тал 100 хувь асуудлаа тулгахгүй. Гэхдээ бид Үндсэн хуулийн 6.2-оо юутай ч давж Монголын ард түмэнд 51 хувийг нь үр өгөөжийг хүртээх энэ яг санхүүгийн модель дээрээ суурилсан гэрээг хийж чадсандаа л бас энэ хэлэлцээ амжилттай болсон гэж ойлгож байгаа. НӨАТ-ын асуудал бол зайлшгүй ярих ёстой асуудал. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 12.1.7-д заасан бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын үнэлгээнд “тэг” хувийн НӨАТ-ыг ноогдуулах бөгөөд энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 12-ийн 5 дахь хэсгийг үл хөндөнө буюу Засгийн газрын эцсийн бүтээгдэхүүнийг шийдэх бүрэн эрхийг тогтворжуулахгүйгээр бид хэд хадгалж үлдсэн. Тэр хэсэг бол тогтворжихгүй. Жишээ нь, Засгийн газар эцсийн бүтээгдэхүүнийг шийтгэх буюу шийдсэний дараа бол тэр НӨАТ-ыг тэглэж байгаа эцсийн бүтээгдэхүүн гэж үзэж байгаа дээр тогтворжилтын ойлголт байхгүй учраас түүнд санаа зовохгүй байж болно.

Тэр үл ялгаварлах зарчим барья гэдэг. Яг үнэндээ амьдрал дээр юу болсон бэ гэхээр уран эцсийн бүтээгдэхүүн биш гэж үзвэл та нар нүүрсийг угаачхаад угаасан нүүрсээ эцсийн бүтээгдэхүүн гэж үздэг. Тэгвэл уул уурхайн бүтээгдэхүүнээ тэр жагсаалтаа шинэчлээд л бүгдийг нь эцсийн бүтээгдэхүүн биш гээд л үзчихвэл бид адилхан гоё хандаад явъя гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр тэр хэсгийг тогтворжуулаагүй. Тэгэхээр гэрээ байгуулагдлаа гээд Засгийн газар бүтээгдэхүүнүүд дээр ижилхэн хандаад эцсийн бүтээгдэхүүн биш юм гээд ингээд үзчихвэл асуудал байхгүй. Гэтэл яг үнэндээ бол энд асар том ашиг сонирхол байгаа юм байна лээ л дээ.

Ер нь тэгээд л Монголд чинь ингээд л нэг зүйлийг хөндөөд л ингээд явахаар очоод нэг газар хана мөргөчих юм. Тэгээд дандаа ашиг сонирхолтой бүлгүүд энэ олон байх юм. Тэгээд энэ том том төслүүд урагшлахаар зарим газар байж ядах юм нээрээ үнэхээр. Тэгээд мань мэт шиг ингээд ийм уул уурхай байтугай нүүрс тээвэр, юунд ч ашиг сонирхолгүй хүмүүс чинь болохоор тэр нөхдүүдтэй тэгж найран дундаа орж хэл амаа ололцохгүй л дээ. Тийм учраас тулгаад байгаа байхгүй юу. Та нар НӨАТ дээр бол яг үнэндээ угаасан нүүрсийг эцсийн бүтээгдэхүүн биш гэж үзэх л ёстой шүү дээ. Тэгээд энийг ингээд хийе гэхээр улс төрчид, тэгээд хэсэг бүлэг нөхдүүд дэмжих үү? Намайг ингэж хэллээ гээд л уржигдар би ингэж хэлсэн тэгээд л намайг бас барьж идэх гэж байна лээ л дээ. Тэгнэ л дээ тэр чинь ашиг сонирхол нь хөндөгдөөд байгаа юм чинь. Угаасан нүүрсийг угаасан л нүүрс шүү

дээ. Тэд нарыгаа эцсийн бүтээгдэхүүн гээд байр ярьж байгаа орон байж болохгүй шүү дээ. Тэгэхээр энийг харин Их Хурал ч бай, Засгийн газар ч бай ер нь хамгаалаад шийдэх л ёстой. Тэгсэн цагт бол ураныг ч гэсэн адилхан шийдээд л явна. Тэгэхээр энийг харин та бүхнийг дэмжихийг хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Тийм, тэгээд гэрээн дээрээ яг энэ асуудлаараа маш тодорхой протоколоо их сайн хөтөлж, тодорхой тохиролцоонд хүрэх хэрэгтэй. Хожим ямар нэгэн байдлаар шийдвэр гарсны дараа бас л бусад хөрөнгө оруулагч нартаа үүсдэг зарим төрлийн татварын маргааны нэгэн адил энэ төслийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх байдалд очуулж болохгүй. Тийм учраас энэ гэрээгээ хийхдээ бас онцгой анхаарах ёстой шүү энэ дээрээ.

Хэн нэмэлт хариулт өгөх үү? Уул уурхай, аж үйлдвэрийн яам Намчинсүрэн. Ажлын хэсгийн 15 дугаар микрофон.

Г.Намчинсүрэн: Золжаргал гишүүний асуултад хариулъя. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам Намчинсүрэн.

Таны ойлгож байгаа зөв. Үндсэндээ төсөл хэрэгжүүлэгч компани маань өөрөө элементийн хүхрээс хүхрийн хүчил үйлдвэрлэх үйлдвэрийг барина гээд ТЭЗҮ дээрээ тусаад ороод ирчихсэн байгаа. Тэгэхээр бид нар бол Эрдэнэт үйлдвэр дээр, Эрдэнэт үйлдвэрийн зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрээс элементийн хүхэр үйлдвэрлэх туршилтыг бол Хятадад хийгээд дуусаж байна. Эрдэнэт үйлдвэрээс бол элементийн хүхрийн үйлдвэрээ барих ТЭЗҮ-ээ ирэх долоо хоногоос бараг манай яаман дээр ирүүлчхэж байгаа болов уу. Тэгээд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр уг асуудлыг хэлэлцэнэ. Тэгээд энэ Эрдэнэт үйлдвэр бол жилдээ 182 мянган тонн хавьцаа элементийн хүхэр үйлдвэрлэхээр бол төлөвлөж байгаа. Энэ төсөл дээр нийтдээ жилдээ 208 мянган тонн элементийн хүхэр.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Жаргалсайханы Золжаргал гишүүн тодруулж асууя.

Ж.Золжаргал: НӨАТ-ын тал дээр их тодорхой бичихгүй бол ер нь аягүй ойлгомжгүй буцаад бас эргэж буцсан нээх тийм их хэл амтай юм болчих вий гээд энэ дээр анхаараасай гэж хүсэж байна.

Хоёрдугаарт нь элементийн хүхэр үйлдвэрлэхэд нөгөө Эрдэнэтийн зэс чинь илүү их зардалтай, төвөгтэй болно шүү дээ. Тэгээд нэгэнт 2 төсөл ингээд зэрэг явахаар тодорхой болчихсон заавал ингэж элементээ хүргэж хаалгүйгээр хүхрийн хүчлийг нь Монголын үйлдвэрээс зардал багатайгаар гараад очихоор нь нөгөөх нь бэлэн юмыг нь аваад ашигладаг ийм л юм баймаар байх юм. Энэ дээр анхаараасай гэж хүсэж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Санал хэллээ.

Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн? Алга байна. 2 гишүүний асуулт асууж, уг хэлсний дараа санал хураалт явагдана. Гишүүдэд мэдээлэл хүргэе. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууж, уг хэлье.

С.Ганбаатар: Сар гаран ярьсан. Одоо хоёр яс салах гэж байгаа улсууд шиг л байх шив дээ. Өнөөдөр ингээд дуусгана гээд л бөөн баяр л байх шиг байна.

Найзууд минь энэ гэрээг та нар аваад байгуулна. Араас нь Улсын Их Хурлын гишүүд бид бас хяналт, хариуцлага тооцож, араас нь байнга хянаж байх нь Монголын ард түмний бас өмнө хүлээсэн хариуцлага, үүрэг шүү гэдгийг онцгойлж хэлье.

Нэгдүгээрт, би хоёр зүйл л байнга асуусан. Цацраг идэвхт аюултай хог хаягдлыг устгах, булшлах тэр хуулийнх нь нэр томъёог нь та нар хэлээрэй. Ийм үйлдвэрийг хөрөнгө оруулагч тал барина гэдгийг та нар баталгаажуулж, хэлэлцээрт оруулсан гэдгээ сайн хэлээд өгөөч. Боломж байна уу? Хэдэн төгрөг вэ гэдгийг би өчигдөр асуусан. Та нар мөнгийг нь хэлбэл бүр сайн байна. Хэдэн төгрөгөөр барих юм?

Хоёрдугаарх нь Монгол орон 2 үйлдвэртэй болоод үлдэг л дээ ядаж. Хоёрдугаарх нь хүхрийн хүчлийн үйлдвэр барина. Бид энэ бүтээгдэхүүний орц, нормоороо энэ үйлдвэрлэлийн явцыг бас хянана гэсэн үг. Олон талтай үнэн. Энэ дээр нийт зардлын 20-иод хувийг хангаж байгаа шүү дээ. Тэгэхлээр энэ хүхрийн хүчлийн үйлдвэрийн цаад мөн чанар бол Монгол орон мөрөөдөл болсон зэс хайлах үйлдвэртэй болно л гэсэн үг. Ер нь яг зэс хайлах үйлдвэр барья гэхлээр л хүхрийн хүчлээ, элементийн хүхрээ яах вэ л гэдэг энэ том боломж энэ дээр тийм боломж байгаа, барихаар болчихсон, хэдий хугацаанд, хэдэн төгрөгөөр вэ гэдгээ хэлж өгөөч. Боломж байна уу? Хоёрдугаарт.

Гуравдугаар зүйл, Одоо ТЭЗҮ-гээ хэзээ эцэслэн батлах вэ? Гишүүдэд шаардлагатай бол тэр гарын үсгийг нь зураад хэзээ танилцуулах вэ? Ямар ч ТЭЗҮ-гүйгээр гэрээ байгуулах гээд зүтгэнэ гэдэг бол бид та таа тунгаагдаж байна л гэсэн үг шүү дээ. Хэзээ өгөх вэ? Надад асуултад хариулах боломж байна уу?

Гуравдугаар асуулт. Менежментийн зардал буюу үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын зардлын 4 хувийг нь Францууд авна гэж байгаа. Борлуулалтын орлогоос буюу маркетингийн зардал 2 хувийг авна гэж байгаа юм. Энэ зардал нэмэгдэхэд манай өгөөж гэдэг үг битгий хэрэглээрэй. Оюу толгой ч гэсэн өгөөжийн 54 хувь нь Монгол байна л гэж байсан. Өдөр болгон сая доллар орж ирнэ л гэж байсан. Монголын нийт төсвийн гуравны нэгийг нуруундаа үүрнэ л гэж ярьсан. Бүгд худлаа болсон. Харин энэ зардлууд нэмэгдэхэд бидний авах ашгийн хэмжээнд нөлөөлөх үү? Нөлөөлөхгүй гэж хэлээд өгвөл боломж бий юу?

Ингээд эцэст нь хэлэхэд хүмүүс мартчихсан байх. Анх юуг ярьж энэ хууль яаж орж ирсэн бэ гэвэл Цөмийн энергийн тухай хуулийн 5.2, 5.3 буюу бид уранаа, газар доор байгаа уранаа, баялгаа өгөөд оронд нь үнэ төлбөргүйгээр санхүүгийн ямар ч эрсдэлд оруулахгүйгээр 51 хувь, 34 хувийг төр үнэ төлбөргүй шууд эзэмшинэ гэдэг юмнаасаа татгалзаж байгаа. Тэгсэн одоо энд энэ танилцуулга дээр ороод ирчихсэн байна. Орж ирэхдээ Засгийн газар нь бүтээгдэхүүний 10 хүртэл хувийг, хүртэл гээд үг орчихсон байгаа юм шүү. Хүртэл. 10 хувийг гэж шууд яагаад хэлж болоогүй юм? Хөрөнгө оруулагчтай ижил нөхцөл, болзлын дагуу худалдан авахаар гэрээний төсөлд тусгалаа гэж үг гарч ирсэн. Үгүй ээ энэ чинь үнэ төлбөргүй юмаа өөрөө өөрөөсөө яаж худалдаж авдаг юм бэ? Энэ дээр надад тайлбар гаргаж өгөөч.

Эцэст нь хэлэхэд зэсийн дараагийн том ордны гэрээ яг энэ шиг орж ирсэн бол та нар маань агуу юм хийж байгаа. Оюу толгой дээр бид ер нь цөм алуулсан. Биднийг үгүй мөн ухаантай болгосон Оюу толгойдоо бас би баярлаж байгаа.

Тэгэхлээр энэ даанч уран юм даа. Уран үнэ цэн гэхээс илүү маш их ховор зүйл байхгүй юу даа.

Д.Амарбаясгалан: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ням-Осорын Учрал хариулт өгье.

Н.Учрал: Тийм, Ганбаатар гишүүн ингэж санаа зовниод байгаа нь зөв. Өнгөрсөнд гаргасан бид нар сургамжийг хэзээ ч мартаж болохгүй. Оюу толгойн гэрээг хэлэлцэж байхад хүснэгт дээр, энэ хүснэгт надад байна л даа. Энэ дээр 20 хувийн ноогдол ашиг авна гээд 998 сая доллар гэнэ үү ингээд байсан юм байна лээ. Тэгээд одоо ноогдол ашиг авсан зүйл байхгүй л байна. 2010 оны Оюу толгойн ТЭЗҮ дээр нийт 2010-23 онд Монгол Улсын Засгийн газарт 6.2 тэрбум доллар орно гэж ингээд байсан юм. Яах вэ бид нар тэр Оюу толгойн тэр санхүүгийн модель энэ тэр нь байхгүй байгаа учраас ингээд тооцоолол хийхэд. Тэгэхэд 23 оны бодит байдлаар гүйцэтгэл нь 2.8 тэрбум доллартой л байна. Тэгээд энэ бол нөгөө 5 хувийн АМНАТ-аар л олсон орлого л бараг болж байгаа байхгүй юу.

Тэгэхээр бид хэрвээ өнөөдөр Оюу толгой төсөл дээр яг өнөөдөр бидэн шиг нөгөө 51 буюу, хэрвээ 51-д хүрэхгүй байгаа тохиолдолд үлдсэн дээр нь өгөөж тохируулах юм бол ямар байх боломжтой байсан бэ гэхээр Оюу толгойн гэрээнд 50 дээр нэмэх 1-ийн өгөөжийн тохируулга байсан бол Засгийн газар нийт нэмэлтээр жил бүр 352 сая ам.долларыг авах бололцоотой байсан. Тэгээд үүнийгээ бид алдчихсан. Тэгээд 34 хувиа авна авна гээд л ингээд л яваад байсан ноогдол ашиг одоо хүртэл хуваарилагдаагүй.

Тэгэхээр бид нар эцсийн үр дүнд Монголын ард түмэн дийлэнх нь ирэх ёстой учраас бид түүнийг Их Хурлын тогтоолоор орлуулаад явж байгаа бас эзэмшлээсээ татгалзаад байгаа зүйл байхгүй. Энэ төслийг хэрэгжүүлэхдээ аль нь илүү ашигтай байх вэ? Тийм учраас 2031 онд анхныхаа ноогдол ашгийг өгнө гэдэг ийм ТЭЗҮ-тэй. Гэтэл 2028 оноос тусгай АМНАТ-ыг авснаараа иргэдийн хуримтлалын данс руу шилжих чинь 28 оноос уурхайн ашиглалтад орсны дараа ингээд эхэлнэ. 31 оноос ноогдол ашиг гэж. Оюу толгой бол ноогдол ашиг өгнө өгнө гэж явсаар байгаад ингээд цаг хугацаа нь хойшлоод байсан. Тийм учраас энэ удаагийн гэрээний гол онцлог бол 51-ийгээ хангуулахад л оршдог. Тийм учраас мэргэжлийн баг, экспертүүд, энэ эрдэмтэн судлаач нар, манай салбарын сайд нар ажлын хэсгээ ахлаад ийм тодорхой үр дүнд хүрсэн гэдгийг хэлэх ёстой.

Тэгээд Ганбаатар гишүүнд хэлэхэд ТЭЗҮ байхгүй гэж ярьж болохгүй л дээ. 2015 онд тэр үеийн үнээр 66 доллар байх дээр ТЭЗҮ анх батлагдсан. Тэрнээс хойш энэ апдэйт/update/ хийгдээд явж байгаа. Яагаад өнөөдөр эцсийн байдлаар алх цохиод Аж үйлдвэр, эрдэс баялгийн зөвлөл шийдээгүй байна вэ гэвэл Их Хурлын нөгөө стратегийн ордын төрийн эзэмшлийн 34-ийг орлуулах тогтоолыг хүлээж байсан. Тэрнээс биш өнөөдөр бол 80 доллароор тооцоод ингээд шинэ ТЭЗҮ бэлэн байна. Гол нь Их Хурлын нөгөө стратегийн ордыг орлуулах тогтоол албажих ёстой байсан. Ингээд батлагдсан учраас бид нар 1 дэх, ирэх долоо хоногт ТЭЗҮ-г албажуулаад дуусна гэж Аж үйлдвэрийн яамнаас ийм төлөвлөгөөтэй.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгээс нэмэлт хариулт өгөх хүн байна уу? Ажлын хэсгийн 16 дугаар микрофон.

Ц.Уранчимэг: Ганбаатар гишүүний асуултад нэмж хариулъя.

Саяын хог хаягдлын менежмент дээр хэдэн төгрөг тусгасан байгаа вэ, аюултай хог хаягдал, цацрагийн хог хаягдал гэдэг дээр. Тэгэхээр хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэхэд 2.3 сая долларыг яг ТЭЗҮ дээр бол урьдчилсан байдлаар тусгасан байна. Мөн энэ дээр бас эрсдэлийн үнэлгээг тусдаа, мониторингийн хяналтын үнэлгээ тусдаа гээд ингээд явж байгаа. Энгийн хог хаягдал, ялангуяа үйлдвэрийн хог хаягдлыг бол эргүүлэн ашиглах ийм технологийг хэрэглэнэ. Аюултай хог хаягдлыг яг үйлдвэрээ бариад уурхайн төсөл дээр хэрэгжүүлэхээр бол энэ гэрээний 9.2.Б дээр тусгасан байгаа. Тэгэхээр энэ зардалд ТЭЗҮ, мөн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд тусгасны дагуу үйл ажиллагааг явуулна.

Гэхдээ энэ дээр бас ялгаж ойлгох юм бол яг энэ аюултай хог хаягдал, бага цацрагт хог хаягдал 2 бас хуулиараа ялгаатай зохицуулалттай бай.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Нэмж хариулах уу? 16 дугаар микрофон нэмэлт минут.

Ц.Уранчимэг: Хог хаягдлын тухай хуулиараа аюултай хог хаягдал маань 3 зэрэглэлд ангилагддаг. Тэгэхээр дугуй, тос, тосолгооны материал, мөн бусад хог хаягдлыг 1, 2, 3 дугаар зэрэглэлийнхээ бүгдээрэнг нь аюултай гэдэг ангилалд байна гэж ойлгодог бас ийм буруу ойлголт байгаа. Тэгэхээр олон нийтэд бид нар цаашид яг энэ аюултай хог хаягдал, бага цацрагт хог хаягдлын талаар нэлээн шинжлэх ухааны дэлгэрэнгүй яг энэ үйлдвэрээс гарч байгаа төсөл хэрэгжүүлэх явцад гарах хог, хаягдлыг дэлгэрэнгүйгээр танилцуулж ойлгомжтой байдлаар ойлгуулна гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Аж үйлдвэрийн яам Намчинсүрэн. Ажлын хэсгийн 16 дугаар микрофон.

Г.Намчинсүрэн: Ганбаатар гишүүний асуултад нэмж хариулъя.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл дээр бол энэ ТЭЗҮ-ийн тодотголыг бол хэлэлцчихсэн. Сая Учрал сайд үндсэндээ хэлчихлээ Их Хурлын тогтоол албажихаар санхүүгийн модель дээр нь хувиа орлуулах л асуудал үлдчихээд байгаа юм. Бусдаар бол хэлэлцээд хүлээгээд авчихсан. Энэ “Бадрах Энержи” ХХК-ийн ТЭЗҮ-ийг бол ШУТИС-ийн харьяа Уул уурхайн хүрээлэн бол боловсруулаад Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлчихсэн байгаа гэж танд хэлэхээр байна.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 16 дугаар микрофон. Аж үйлдвэрийн яам Намчинсүрэн.

Г.Намчинсүрэн: Хүхрийн хүчлийн үйлдвэрт бол төсөл хэрэгжүүлэгч бол ТЭЗҮ-д заасныхаа дагуу 96.2 сая долларыг бол төсөлд зарцуулахаар төсөлд тусгаад ороод ирчихсэн. 2028 оноос баригдана. Олборлолтын 3 дахь жилээс эхлээд үйлдвэрийг ашиглалтад оруулна. Хүчин чадал бол 700 тонн хүчил өдөрт, тэгээд эрчим хүч бол 7.4мвт эрчим хүч бас үйлдвэрлэхээр тусгагдсан байгаа.

Д.Амарбаясгалан: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн тодруулж асууя.

С.Ганбаатар: Би бол энэ цагаан дээр хараар бичсэн зүйлүүдийг л уншаад байгаа. Ерөөсөө санаанаас зохиосон юм байхгүй. 9.2.Б дээр аюултай хог хаягдлыг дахин боловсруулах, устгах үйл ажиллагааг уурхайн талбайд хэрэгжүүлнэ л гэж байгаа юм. Үйлдвэр барина гэж байхгүй. Азаар харин та маань ингээд үйлдвэр барина гэж хэлсэнд магнайгаа хагартал баярлаж байгаагаа хэлье. Энэ чинь протоколд тусаж байгаа юм шүү дээ энэ чинь.

Хоёрдугаарт, хүхрийн хүчлийн үйлдвэр барина гэж орууллаа. Энэ дээр манай хэлэлцээр хийж байгаа энэ манай баг сайн зүйл оруулсан зүйлүүд бий шүү бас энэ 11.3.Б-д би их баярлаж байгаа. Боломжит үнээр гэж. Зах зээлийн үнээс илүү монголчуудад давуу талтай байдлыг бас энд гаргасан байгаа. Олон зүйлүүд байгаа.

Эцэст нь ер нь хөндлөнгийн бие даасан үндэсний болон олон улсын шинжээчдийг та нар нэрлээч. Санхүүгийн модель боловсруулсан, ашгийн өгөөжийн моделийг боловсруу.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Нэмж хариулт өгье. Хүхрийн хүчлийн үйлдвэр “Мон-Атом” компанийн захирал Далайжаргал хариулт өгье. Ажлын хэсгийн 18 дугаар микрофон.

Д.Далайжаргал: Хүхрийн хүчлийн үйлдвэрийг байгуулна. Француудтай ярьж байгаа юм нь энэ орчихсон байгаа юм. Та санаа зоволтгүй. Француудтай энийг хийгээд хүхрийн хүчлийн үйлдвэрээ байгуулна. Бид нар хүхрийн хүчлийг Хятадаас юм уу, урдаас оруулж ирэхээсээ оронд байгуулъя гэдэг юм байгаа. Эрдэнэтийн зэс хайлуулах үйлдвэрээс элементийн хүхэр гарна. Тэн дээр хүхрийн хүчлийг түшиглэж хүхрийн хүчлийн үйлдвэр байгуулна.

Д.Амарбаясгалан: Шинжээч. Эрдэнэс Монголын захирал Наранцогт захирал нэмж хариулъя. Нөгөө талын чинь микрофон асчхаж. Ажлын хэсгийн 19 дүгээр микрофон.

С.Наранцогт: Ганбаатар гишүүний асуултад нэмж хариулъя. Бид нар энэ дээр хуулийн, санхүү, эдийн засгийн, байгаль орчны чиглэлээр гадаадын энэ чиглэлээр ажилладаг туршлагатай энэ олон улсын зөвлөх үйлчилгээний компаниудтай ажиллаж, эдний зөвлөгөөг гэрээ, хэлэлцээнийхээ хувьд авч ажиллуулсан.

Тухайлбал, санхүү дээр “Си Ар Эс” гэж байгаа. “Си Ар И” энэ бол Америкийн компани байгаль орчны чиглэлээр, бас хуулийн чиглэлээр ингээд бүгд нэр хүндтэй. Дээр нь нэмээд Монголын дотоодын хуулийн компани, дотоодын хуулийн зөвлөх, дотоодын санхүүгийн зөвлөх эд нар дандаа нөгөө “Си Пи Эй” буюу санхүүгийн олон улсын хөрөнгө оруулалтын сертификаттай ийм мэргэжилтнүүд манай өөрийн санхүүгийн моделийг.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: 1 гишүүн асуулт асууж, үг хэлсний дараа санал хураалт явагдана. Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууж, үг хэлье.

Д.Ганбат: Энэ Засгийн газар бас Улсын Их Хурал болсон, болоогүй баахан юм ярьж байгаа. Хамгийн боломжтой зүйл нь дэмжүүштэй нь энэ Оранотой

байгуулж байгаа гэрээ гэж үзэж байна. Энийг дэмжиж байна. Хурдан түргэн тэгээд явуулах ёстой байх.

Улсын Их Хурал ингээд асуудлыг хэлэлцээд, ярилцаад ингэж чадаж байна л даа. Болж байна л даа Ораногийн талаар ойлголтыг нь ард түмэнд өгөөд. Бусад юман дээр ингэж чадахгүй байгаа шүү. Ер нь 1 шөнийн дотор л юм өөрчлөгдөж байна шүү дээ. Тэгээд ард түмнийхээ асуу, тодруул гэсэн юмыг чадахгүй байна шүү бид нар заримдаа. Солонгос энэ тэрийг хар л даа. 1 шөнийн дотор юу болж байна? Тийм тэгэхээр энэ дэгээ жоохон янзалсан нь дээр байх. Их олон хүн асуугаад, шалгаагаад байх юм байхгүй, яриад байх юм байхгүй. Гишүүд юмаа чуулган дээрээ ярьчихдаг байх нь зүйтэй гэсэн ийм зүйлийг хэлмээр байна.

Хэд хэдэн зүйл тодруулъя. Энэ Орано гэдэг компани маань өөрөө бас хувьцаат компани байгаа шүү дээ. Бүр Мицубиши хүртэл оролцоод ингээд явж байгаа ийм компани. Тэгээд энэнийхээ юу яамаар байх юм. Энэ компани маань уул уурхай, байгаль орчинд нөлөөгүй тийм уул уурхай байхгүй. Хорвоо дээр, дэлхий дээр. Тэрийг бүгд мэдэж байгаа. Тэгэхдээ энэ компани маань хамгийн сайн технологи, хамгийн тэргүүний техник, технологийг ашиглаад уранаа олборлоно гэсэн ийм баталгааг нь авч байгаа юу? Албан бичгээр тэр баталгааг нь авах хэрэгтэй. Тийм. Энэ талаар надад тодруулаад өгчхөөрэй.

Нөгөө юм нь стратегийн орд гэж ямар ордыг хэлдэг, ярьдаг юм? Бас их л маргаантай зүйл байдаг шүү дээ. Стратегийн бүтээгдэхүүн гэвэл би энэ уран байж болох байх гэж бодоод байна. Яагаад вэ гэхээр зэвсэглэлд ч ашигладаг, янз бүрийн зүйлд ашигладаг ийм зүйл байгаа. Газрын ховор элемент энэ 2 ийм байгаа байх. Тэгээд энэ гаргасан бид нар хэдийгээр 10 хувийг эзэлж байгаа боловч нэгэнт гарч байгаа бүтээгдэхүүнийхээ 50 хувийг өөрөө хэнд борлуулахаа мэддэг байвал зүгээр байна. Энэ талаар зүйл, заалт орох уу?

Гуравдугаарт бас юм байна. Иргэддээ л сайн юм хийгээд өгчхөөч. Франц Монгол хоёрыг хооронд нь харилцан визгүй зорчдог энэ юмыг дагалдуулаад хийчихмээр байх юм. Хэрэв Франц визгүй бол бүх улс орнууд визгүй болох байх. Бид нар чинь 3-хан сая хүнтэй шүү дээ. Насанд хүрсэн 2 сая орчим хүн байгаа байх. 800 мянган айл л байгаа шүү дээ. Гэтэл одоо яаж байна? Тогны үнэ нэмчихсэн, янз бүрийн татвар нэмчихсэн, өдөр болгон доллар 1 төгрөгөөр өсөж байгаа, мөнгөний ханш унаж байгаа ийм хүнд хэцүү нөхцөл байна шүү дээ. Тэгээд ийм юмыг хамтруулаад хийгээд өгчихвөл энийг явчихна гэж ойлгож байна. Энэ боломжтой юу, энэ талаар ярилцаж байгаа юу гэсэн ийм асуултууд байна.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ням-Осорын Учрал.

Н.Учрал: Тэгээд 28 жилийн дуусдаггүй яриаг бид дуусгах гэж байна. Тэгэхээр энэ дуусдаггүй ярианд авлига, ашиг сонирхлоос болж энэ дуусдаггүй яриа гацсан юм байна лээ. Тийм учраас энэ удаагийн ажлын хэсэг бол Франц талтай ямар нэгэн байдлаар хоол унд идэж, кофе хамт ууж, найзан дундаа ороогүй. Монголын эрх ашгийг төлөөлж, Үндсэн хуулийн 19 оны өөрчлөлтийг хангуулахаар өөрсдийн санхүүгийн схем, моделийг боловсруулж, гадаад болон дотоодын хууль, санхүү, байгаль орчны чиглэлийн зөвлөхүүдийн хамтын хүчээр энэ хэлэлцээрийг амжилттай хийж дуусаж байгаа.

Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Пүрэвдоржоор ахлуулсан Их Хурлын гишүүд, баг бүрэлдэхүүн Казакстанд очиж ажилласан. Яг энэ газрын доороос уусган олборлох технологийг бас нүдээр харж, Казахстаны сайн туршлагуудыг бол бас авч хэрэгжүүлж, энэ ажлын хэсгийг ахалж Их Хурлын гишүүдэд маш зөв ойлголт өгч, дэмжиж ажилласанд бас би Пүрэвдорж ахлагчдаа, ажлын хэсгийнхэнд бас талархаж байна.

Ингээд Ганбат гишүүний хэлсэн асуудал дээр энэ шинэ, дэлхийн уран дээр бол 51 хувийг нь л энэ газрын доорх уусган олборлох технологиор олборлож байгаа юм байна лээ. Дээрээс нь Цөмийн энергийн хуулиар бол уран бол өөрөө стратегийн ордод хамаардаг. Тийм учраас үүний 34 хувийг нь тэр эзэмших ийм хуультай Баялгийн сангийн хуулиар. Их Хурлын тогтоолоор тодорхой. АМНАТ-аар анх удаа хөрөнгө оруулалтын гэрээнд өсөн нэмэгдэх АМНАТ-ыг оруулж ирж, дээрээс нь Үндсэн хуулийн 6.2 хангагдахгүй бол өгөөжийг тохируулах буюу нөгөө талаасаа 51 хүрэх зардлыг гаргуулж авсан ийм гэрээг хийж чадлаа.

Тэгэхээр байгаль орчны чиглэлээр Германы “Гео энерги консалтинг”, хуулийнхаар “White&Case”, санхүүгээр “Си Ар Эй” гээд ийм байгууллагууд ажилласан. Тэгэхээр энэ нөхдүүдийн хамтын хүчин чармайлтаар авч гарсан. Тэгэхээр 5 салбарын сайдаар ахлуулсан энэ ажлын хэсэг бол өөрөө Монгол талын эрх ашгийг хангуулахад хамтран хичээж зүтгэсэнд бас би бас гүнээ талархаж байна. Тэгээд энэ хөрөнгө оруулалтын гэрээг явуулахад олон Цөмийн энергийн хууль, Үндэсний баялгийн сангийн хуулиар тусгай АМНАТ-аар орлуулсан хэсэг иргэдийн хуримтлалын дансанд харагдаж, 2028 онд анх удаа тусгай АМНАТ-ыг авч эхлэх үед, уурхай ашиглаж эхлэх үед иргэд гар утсан дээрээ тэр тусгай АМНАТ-аас орж ирэх хуримтлалыг хардаг болох нөхцөл бүрдлээ.

Дээрээс нь Европын холбооны Аюулгүйн зөвлөлийн 5 орны 1 Францтай хамтарч ажилласнаараа бид нар хөрөнгө оруулалтын орчныг сайжруулж байна. Зөвхөн энэ Францын асуудал биш 8 оронд энэ түүхий эд, бүтээгдэхүүнээ нийлүүлснээр Европын 8 орныг эрчим хүчээр хангах ийм орон болох нөхцөл.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Дашдондогийн Ганбат гишүүн тодруулж асууя.

Д.Ганбат: Яах вэ бид нар юу яаж байгаа л даа. Тэр Баялгийн сан гээд л баахан мөнгө цуглуулаад л тэгээд бид нар чинь сангаа олигтойхон шиг ч яачхаад бариад чаддаггүй шүү дээ. Тэгээд л дараа нь тэр нь тоногдоод л ингээд л дуусдаг л даа. Тэгээд энэ Баялгийн сан тэрний араас битгий орчхоосой гэж бодож байна. Уул нь яг иргэддээ л хувьцааг нь эзэмшүүл л дээ. Иргэд чинь хувьцаагаа барьцаалаад, зараад ингээд ингээд л явдаг шүү дээ. Тэгээд монголчууд болохоор яагаад болохгүй болчхож байгаа юм? Одоо наад хувьцааг чинь иргэдэд эзэмшүүлэх боломжтой юу? Заавал тэр Баялгийн сан дээрээ л бүгдийг нь хамаад байх юм. Ер нь тэр Баялгийн сан гэдэг чинь авлигагүй тийм газрын л эд байх л даа. Манайх шиг авлига нь жил болгон тэгээд л байраар өгсөж байдаг ийм улс орон энэ сан нь дандаа л ямар ч тийм амжилттай сан байхгүй гэж бодож байна. Тэрний араас орох юм биш биз дээ?

Д.Амарбаясгалан: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ням-Осорын Учрал нэмж хариулт өгье.

Н.Учрал: Үндэсний баялгийн сангийн хуулийг та бид баталсан. Тэр хууль дээр бол Хуримтлалын сан бол иргэдийн сан. Тэгэхээр саяын 5 компаниас орж ирсэн 480 гаруй тэрбум төгрөгийг иргэдэд хуваарилаад үзэхээр 138 мянга болж байгаа. Та бидний баталсан Үндэсний баялгийн сангийн хууль Ашигт малтмалын өнөөдрийн хуулиар тусгай АМНАТ-аар орлуулсан хэсэг шууд иргэдийн хуримтлалын данс руу шилжиж байгаа. Энэ мөнгө төгрөг нь бол Монголбанкны дэргэд байна.

Тэгэхээр хэн нэгэн халдахгүй гэсэн үг. Тэгэхгүй бол яг Нийгмийн даатгалын сан шиг самарна. Тийм учраас энийг тэнд нь байлгаад, иргэд өөрөө хянадаг И-Монголоороо нээлттэй хардаг, тэгээд түүнийгээ эрүүл мэнд, боловсрол, орон сууцдаа зарцуулдаг энэ зөв тогтолцоо руу явахгүй бол үнэхээр бас бэрхшээлтэй юм байна шүү. Энэ бас ажлын хэсгийг ахалж байх үед харлаа.

Гэхдээ энэ бол ирээдүй хойч үедээ мэдрэгдэх ирээдүй хойч үе энэ Баялгийн сангийн хуримтлалаараа эрүүл мэнд, боловсрол, орон сууцдаа зарцуулахад хуримтлалд нэмэр болох төсөл болсон гэдгийг санхүүгийн тооцоолол дээр гаргасан.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Байнгын хорооны саналаар гэрээний төслийг бүхэлд нь зөвшөөрч, тухайн гэрээнд гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгохыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Санал хураалтад 97 гишүүн оролцсоноос 71 гишүүн дэмжиж, 73.2 хувиар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Дашдондогийн Ганбат, Хассуурийн Ганхуяг, Замира гишүүн, Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн нарыг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлье.

Энэ санал хураалгаж байгаа саналын томъёолол Улсын Их Хурлаар хэлэлцээд дэмжиж байгаа шийдвэр, мэдээж Улсын Их Хурлаас гарч байгаа тогтоол бол түрүүний Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороон дээр хураалгасан тогтоолоор явагдана.

Ингээд Байнгын хорооны саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг зөвшилцсөн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталсанд тооцлоо.

Ингээд 1997 онд уг төсөл Монгол Улсад анх орж ирж үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна. 1997 онд уг төсөл анх орж ирж үйл ажиллагаа явуулж эхэлсэн. 2003 онд хайгуулын тусгай зөвшөөрлөө авч байсан байна. 2015 онд ашиглалтын тусгай зөвшөөрлөө авч байж. 2017 онд хамтарсан компани байгуулж, уг төслийн үйл ажиллагаа идэвхжиж байсан байна. Ингээд 28 жилийн дараа түрүүн Баярхүү судлаачийн хэлсэнчлэн геостратегийн, геополитикийн, гео эдийн засгийн асар өндөр ач холбогдолтой уг төсөл Улсын Их Хурлын босгыг давлаа.

Уг төслийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхэд бэлтгэсэн Засгийн газар, уг төслийн ажлын хэсэгт тусгайлан Улсын Их Хурлын нэрийн өмнөөс баяр хүргэж, амжилт хүсье.

Мөн Монгол Улсын эдийн засагт онцгой ач холбогдолтой төслийг идэвхийлэн дэмжиж ажлын хэсэгт болон Байнгын хорооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон Улсын Их Хурлын гишүүддээ бас талархал дэвшүүлье.

Ингээд Шадар сайд, Улсын Их Хурлын гишүүн Тогмидын Доржхандыг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлье. Хоцорч орж ирлээ.

Улсын Их Хурлаар батлагдсан тогтоолын, Саруулсайханы Цэнгүүн гишүүн бас протоколд дэмжсэнээр тэмдэглүүлж байна.

Батлагдсан тогтоолыг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол “Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг зөвшилцсөн тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас Монгол, Францын хамтарсан “Бадрах Энержи” ХХК-ийн хөрөнгө оруулагч Бүгд Найрамдах Франц Улсад бүртгэлтэй “Орано Майнинг” энгийн ХК-тай байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний төслийг зөвшилцөхөөр ирүүлснийг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг зөвшилцсөнд тооцсугай.

2.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн тогтоол байна.

Протоколд тэмдэглэгдсэн, дэмжсэн гишүүдийг тэмдэглэснээр нийт санал хураалтад оролцсон гишүүдийн 79.3 хувиар дэмжигдсэн байна.

Ингээд хоёр дахь асуудал хэлэлцэж дууслаа. Ажлын хэсгийнхэнд талархал дэвшүүлье. Дараагийн асуудалд орёе.

18.47 цаг

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3-т Улсын Их Хурал энэ хуулийн 46.1.2-т заасан хууль тогтоолын эцсийн найруулгатай танилцаж ёсчлохыг зөвшөөрөх гэж заасны дагуу тогтоолын эцсийн найруулгыг Байнгын хороод бэлтгэж Улсын Их Хуралд танилцуулахад бэлэн болсон байна.

1.Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

1. Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн санал хэлье.

Б.Пүрэвдорж: 2023 онд Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх Франц Улсад айлчилж, 26 жилийн туршид гацсан ураны төслийг хөтлөхөөр хэлэлцээр хийсэн. Энэ айлчлалын үеэр тухайн үеийн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга одоогийн Улсын Их Амарбаясгалан хэлэлцээрийн ерөнхий үндсэн суурийг тавьж өгсөн танд баяр хүргэе.

Үүний дагуу өнөөдөр Цөмийн энергийн тухай хууль, “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувийг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоол, Баялгийн сангийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль зэрэг 3 хууль, тогтоолын төслийг манай Их Хурлын гишүүд баталж гаргасан. Эдгээр хууль, тогтоолын дагуу Монгол Улсын Засгийн газар Орано Майнинг хооронд байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээний төсөл сая батлагдлаа. Энэ гэрээний төсөл батлагдсанаар 3 маш чухал асуудлыг шийдвэрлэж байгаа.

Нэгдүгээрт нь Франц, Англи, Герман, Итали, Испани, Бельги, Нидерланд, Швейцар, Люксембург зэрэг Европын холбооны 26 улсын гуравны нэгийг 50 жилийн турш цахилгаанаар хангах ийм боломжийг нээж өгч байгаа.

Хоёрдугаарх нь дэлхийн цаг уурын дулаарал, хүлэмжийн хий ялгаруулалттай тэмцэж байгаа тэмцэлд манай улс хувь нэмрээ оруулж байгаа маш чухал ажлыг хийлээ.

Гуравдугаарт нь уран олборлосон туршлага дээрээ цаашид цөмийн энерги, атомын цахилгаан станц барих энэ боломжийг мөн өөрийнхөө улсад нээж өгч байна. Тэгээд энэ хууль, эдгээр хууль болон тогтоолын төсөл, хэлэлцээр дээр ажилласан нийт ажлын хэсгийнхээ, Их Хурлын ажлын хэсгийнхээ хамт олон та бүхэнд талархсанаа илэрхийлье.

Мөн Засгийн газрын ажлын хэсгийг ахалсан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Монгол Улсын сайд Учралдаа бас баяр хүргэе. Мөн Уул уурхайн сайд Туваандаа бас баяр хүргэе. 40 гаруй ажлын хэсэгт ахалсан эрдэмтэн мэргэд та бүхэндээ бас баяр хүргэе. Тэр дундаа 7 жилийн туршид энэ хэлэлцээрийг амжилттай явуулахад сайн ажилласан “Мон-Атом” компанийн захирал Далайжаргалд бас баяр хүргэе. Мөн сүүлд нь өөрийнхөө туслахууддаа, зөвлөхүүддээ, тэр дундаа тэнгэрт дэвшсэн миний найз Мэргэний Сэргэлэн гэдэг залуу энэ ажлын хэсгийг заавал чи ахлах ёстой гэж надад захиж, зөвлөж байсан найддаа бас баярлалаа. Тэгээд хамгийн сүүлд баталж өгсөн Их Хурлын гишүүд та бүхэндээ хамгийн их талархаж байгаагаа илэрхийлье.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын ажлын хэсгийг амжилттай ахалж ажилласан Улсын Их Хурлын дэд дарга, баруун бүсээс сонгогдсон Бөхчулууны Пүрэвдорж гишүүндээ баяр хүргэе.

Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг сонссонд тооцсон.

“Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг зөвшилцсөн тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу?

Ганзоригийн Тэмүүлэн гишүүн.

Г.Тэмүүлэн: Сая Улсын Их Хурлаар хөрөнгө оруулалтын гэрээний төслийг зөвшилцөхөөр бас Улсын Их Хурал дэмжсэн. Үүнтэй холбогдуулаад бас эцсийн найруулгыг сонсох саналтай байна.

Д.Амарбаясгалан: Ингээд “Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг зөвшилцсөн тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

2025 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаан хэлэлцэх асуудлаа дууссан тул өндөрлөж байгааг мэдэгдье.

18.53цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ
Д.ОТГОНДЭЛГЭР*

